



МОНГОЛ УЛСЫН ТЭРГҮҮН ШАДАР
САЙД БӨГӨӨД ЭДИЙН ЗАСАГ,
ХӨГЖЛИЙН САЙД

Улаанбаатар, Чингэлтэй, 4-р хороо, Самбуугийн гудамж,
Засгийн газрын 11-р байр
Утас: 51263333 Факс: 51263333
Цахим шуудан: info@med.gov.mn
Цахим хуудас: www.med.gov.mn

2025.01.15 № 01/132

танай _____-ны № _____-т

Г МОНГОЛ УЛСЫН САЙД, ХЯНАЛТ, Г
ҮНЭЛГЭЭНИЙ ҮНДЭСНИЙ
ХОРООНЫ ДАРГА Э.ОДБАЯР
ТАНАА

Монгол Улсын Их Хурлын 2023 оны 05 дугаар сарын 30-ны өдрийн 39 дүгээр тогтоолоор батлагдсан Монгол Улсын 2024 оны хөгжлийн төлөвлөгөөний хэрэгжилтийг яамд, байгууллагуудаас ирүүлсэн тайланд үндэслэн нэгтгэн боловсруулж, Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоолоор батлагдсан “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам”-ын 6.2-т заасны дагуу хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж, танилцуулга болон холбогдох тайланг хавсралтаар хүргүүлж байна.

Хавсралт: ... хуудастай.



Эдийн засаг, хөгжлийн яам
Удирдлага
Монгол Улсын Тэргүүн Шадар сайд
бөгөөд Эдийн засаг, хөгжлийн сайд
Лувсанням Гантөмөр

2025-01-16 15:45:02

“МОНГОЛ УЛСЫН ХӨГЖЛИЙН 2024 ОНЫ ТӨЛӨВЛӨГӨӨ”-НИЙ ЖИЛИЙН ЭЦСИЙН ТАЙЛАНГИЙН ТАНИЛЦУУЛГА

Нэг. Зорилго

Хяналт-шинжилгээ, үнэлгээний зорилго нь төлөвлөгөөний гүйцэтгэлийг хүлээгдэж буй үр дүнд хүрч байгаа эсэхийг тогтоох, арга хэмжээ тус бүрийн шалгуур үзүүлэлтийн хүрсэн түвшинг тодорхойлох, шаардлагатай дүгнэлт, санал, зөвлөмж боловсруулах, хэрэгжилтийг хангах болон шийдвэр гаргах түвшинд мэдээлэл, арга зүйн дэмжлэг үзүүлэх, бодлого, төлөвлөлтийг сайжруулах, төсөл, арга хэмжээний гүйцэтгэл, үр дүн, үр нөлөөг нэмэгдүүлэх, хэрэгжүүлэгч байгууллагын хариуцлагыг дээшлүүлэхэд оршино.

Хоёр. Арга зүй

Улсын Их Хурлын 2023 оны 05 дугаар сарын 30-ны өдрийн 39 дүгээр тогтоолын хавсралтаар батлагдсан “Монгол Улсын хөгжлийн 2024 оны төлөвлөгөө”-ний жилийн эцсийн хэрэгжилтэд Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоолоор батлагдсан “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам”-ын 6.2.1, 6.2.2-т заасны дагуу 8 тэргүүлэх чиглэл, 194 төсөл, арга хэмжээ, 205 шалгуур үзүүлэлтийн хүрээнд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийлээ.

Хяналт-шинжилгээ, үнэлгээг хийхдээ урьдчилан тодорхойлсон шалгуур үзүүлэлтийн дагуу “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам”-ын 6.2.1-т заасан аргачлалаар, төсөл, арга хэмжээний хүрсэн түвшинг тоо болон чанараар илэрхийлэх боломжгүй үед хэрэгжилтийн хувийг мөн журмын 6.2.2-т заасан аргачлалаар тус тус үнэлсэн.

Эдийн засаг, хөгжлийн сайдын 2024 оны 12 дугаар сарын 13-ны өдрийн “Хэрэгжилт ирүүлэх тухай” 01/2725 дугаар албан бичгийг 32 төсвийн ерөнхийлөн захирагчид хүргүүлж, холбогдох тайланг албан бичгээр хүлээн авч нэгтгэн боловсрууллаа.

Гурав. Хяналт-шинжилгээ, үнэлгээний дүн

3.1. “Монгол Улсын хөгжлийн 2024 онд баримтлах бодлогын тэргүүлэх чиглэлд туссан зорилгын жилийн эцсийн хэрэгжилт

“Монгол Улсын хөгжлийн 2024 онд баримтлах Бодлогын тэргүүлэх чиглэлд Экспортыг нэмэгдүүлэх, Хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх, Хүний хөгжлийн үзүүлэлтийг сайжруулах, Аялал жуулчлалыг хөгжүүлэх, Хүнсний хангамж, аюулгүй байдлыг сайжруулах, Улаанбаатар хотын түгжрэл, агаарын бохирдлыг бууруулах,

Засаглалын үзүүлэлтийг сайжруулах, Ногоон хөгжлийг дэмжих зэрэг 8 чиглэлийн 23 зорилго, 51 зорилтыг хэрэгжүүлэхээр тусгагдсан.

Монгол Улсын 2024 онд баримтлах бодлогын 8 тэргүүлэх чиглэлийн хүрээнд хэрэгжүүлэх 23 үндсэн зорилгын хэрэгжилт **70.8** хувийн биелэлттэй үнэлэгдлээ.

Хүснэгт 1. “Бодлогын тэргүүлэх чиглэл”-ийн хүрээнд хэрэгжүүлэх үндсэн зорилтын хэрэгжилт

дд	Тэргүүлэх чиглэл	Үндсэн зорилт	Хэрэгжилт /хувь/	Хэрэгжилт /дундаж хувь/
1	Экспортыг нэмэгдүүлнэ	Нүүрсний экспортын биет хэмжээг 50 сая тоннд, зэсийн экспортын биет хэмжээг 1.5 сая тоннд, газрын тосны экспортын биет хэмжээг 6 сая баррельд хүргэж, уул уурхайн салбарын экспортыг нэмэгдүүлнэ.	80.0	78.0
		Гадаад худалдааг хөнгөвчлөх, экспортыг төрөлжүүлэх, хөдөө аж ахуйн гаралтай бүтээгдэхүүний боловсруулалтын түвшнийг ахиулах замаар уул уурхайн бус экспортыг нэмэгдүүлнэ.	76.0	
2	Хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлнэ	Хөрөнгө оруулагчдад дэмжлэг, үйлчилгээ үзүүлэх, хөрөнгө оруулалт татах, хамгаалах цогц механизмыг бүрдүүлэх замаар хөрөнгө оруулалт хийх, бизнесийн үйл ажиллагаа эрхлэх таатай орчныг бүрдүүлнэ.	95.0	68.0
		Геологи, хайгуулын ажлыг эрчимжүүлэн, ашигт малтмалын хайгуулын тусгай зөвшөөрөл олголтыг нэмэгдүүлж, улмаар ашигт малтмалын батлагдсан нөөцийг өсгөнө. Мөн зэсийн ордын ашиглалтыг нэмэгдүүлэх замаар хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлнэ.	70.0	
		Стратегийн ач холбогдол бүхий ашигт малтмалын ордуудын нөөцийг нарийвчлан тогтоож, эдийн засгийн эргэлтэд оруулах замаар Үндэсний баялгийн сангийн тогтолцоог бий болгоно.	90.0	
		Зэсийн баяжмал боловсруулах үйлдвэр, нүүрс баяжуулах үйлдвэр, гангийн үйлдвэр болон ураны олборлолт, хүдрийн баяжмал боловсруулах үйлдвэрүүдийг хувийн хэвшлийн хөрөнгө оруулалтаар байгуулж, боловсруулах үйлдвэрийг нэмэгдүүлнэ.	70.0	
		Эрчим хүчний найдвартай эх үүсвэрийг нэмэгдүүлж, дотоодын хэрэгцээг бүрэн ханган, эрчим хүч экспортлох суурь нөхцөлийг бүрдүүлнэ.	30.0	
		Соёлын бүтээлч үйлдвэрлэлд хөрөнгө оруулалт татаж, соёлын үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлэн соёлын салбарыг эдийн засгийн эргэлтэд оруулна.	50.0	
		Чөлөөт бүсүүдийн инженерийн дэд бүтцийг хөгжүүлж, хөрөнгө оруулалт татах нөхцөлийг бүрдүүлнэ.	70.0	
3	Хүний хөгжлийн үзүүлэлтийг сайжруулна.	Олон улсын шаардлагад нийцсэн мэргэжил, ур чадвартай хүний нөөцийг нэмэгдүүлнэ.	72.5	67.4
		Нийгмийн хамгааллын салбарт нийгмийн даатгалын оновчтой тогтолцоог бий болгох, төрийн албан хаагчдын цалинг үе шаттайгаар нэмэгдүүлэх, нийгмийн зорилтот бүлгийг зөв тодорхойлж, нийгмийн халамжийн сангаас олгох тэтгэвэр, тэтгэмжийн хэмжээг нэмэгдүүлэн нийгмийн баталгааг сайжруулна.	66.0	
		Эрүүл мэндийн салбарын үйлчилгээний чанар, хүртээмжийг нэмэгдүүлж, өвчлөл, нас баралтыг бууруулна.	63.9	
4	Аялал жуулчлалыг хөгжүүлнэ.	Аялал жуулчлалын салбарын бүтээгдэхүүний нэр төрлийг нэмэгдүүлэх, дэд бүтцийн хөрөнгө оруулалтыг түлхүү хийнэ. Мөн агаарын тээврийг либералчлан, нислэгийн тоог өсгөж, жуулчдын тоо, аялал жуулчлалын салбарын орлогыг нэмэгдүүлнэ.	70.0	70.0
5	Хүнсний хангамж, аюулгүй байдлыг сайжруулна.	Хүн амын хүнсний хэрэгцээний гол нэрийн бүтээгдэхүүний дотоодын үйлдвэрлэлийг нэмэгдүүлэн, импортын хамаарлыг бууруулж, нийлүүлэлтийн сүлжээ, аюулгүй байдлыг хангана.	75.0	75.0
6	Улаанбаатар хотын түгжрэл, агаарын бохирдлыг бууруулна.	Улаанбаатар хотын түгжрэлийг бууруулна.	30.0	40.0
		Шинэ суурьшлын бус, дэд төвүүдийг байгуулж, эдийн засгийн бүсчилсэн хөгжлийг дэмжин төвлөрлийг сааруулна.	50.0	
7	Засаглалын үзүүлэлтийг сайжруулна.	Авлига, албан тушаалын гэмт хэрэгтэй тэмцэх ажлыг эрчимжүүлнэ.	100.0	93.3
		Санхүүгийн хориг, арга хэмжээ авах байгууллага (ФАТФ)-аас гаргадаг мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх стратегийн дутагдалтай улсын жагсаалт, Европын холбооны "Татварын зорилгоор хамтран ажилладаггүй бүс нутгуудын жагсаалт"-д орохоос сэргийлж, Монгол Улсын зээлжих зэрэглэлийг хэвээр хадгалж, сайжруулна.	100.0	

		Төрийн цахим үйлчилгээний хүртээмж, төрлийг нэмэгдүүлэх, харилцаа холбооны дэд бүтцийг сайжруулан цахим засаглалын хөгжлийн үзүүлэлтийг нэмэгдүүлнэ.	100.0	
		Төрийн үйлчилгээг авах, хүргэх зардлыг бууруулж, хувийн хэвшлийн бүтээмжийг дэмжих бодлогын оновчтой шийдвэр гаргахад шаардлагатай мэдээллийн сан, цахим системүүдийг хөгжүүлнэ. /Зөвшөөрлийн цахим систем, e-mongolia, гадаад худалдааны нэг цонхны цахим систем/	100.0	
		Төрийн болон орон нутгийн өмчит компаниудын засаглал, үр өгөөжийг сайжруулж, олон улсын чанарын стандартыг нэвтрүүлэн, үе шаттайгаар хувьцаат компанийн хэлбэрт шилжүүлнэ.	90.0	
		Улс төр, нийгэм, эдийн засаг, бизнесийн харилцаа, засаглалын бүх шатанд олон ба гурван талт зөвшилцөл, түншлэл, хяналтын оновчтой, үр дүнтэй тогтолцоог бүрдүүлж, нэвтрүүлэн хэвшүүлнэ.	70	
8	Ногоон хөгжлийг дэмжинэ.	Уур амьсгалын өөрчлөлтийг сааруулах арга хэмжээнүүдийг хэрэгжүүлж, байгаль орчны тэнцвэртэй байдлыг хамгаална.	72.0	72.0
	Нийт			70.8

Тэргүүлэх чиглэлийн шалгуур үзүүлэлт, хэмжих нэгж болон үр дүнгийн үзүүлэлт байхгүй тул явцаар үнэлсэн болно.

3.2. “Монгол Улсын хөгжлийн 2024 оны төлөвлөгөө”-ний жилийн эцсийн хэрэгжилт

Монгол Улсын хөгжлийн 2024 оны төлөвлөгөө нь 24 төсвийн ерөнхийлөн захирагч, 53 хөтөлбөрийн үр дүнгийн хүрээнд 194 төсөл арга хэмжээ, 205 шалгуур үзүүлэлттэй батлагдсан.

Монгол Улсын хөгжлийн 2024 оны төлөвлөгөөнд туссан 194 төсөл арга хэмжээ 205 шалгуур үзүүлэлтийн хэрэгжилт 2024 оны жилийн эцсийн байдлаар дунджаар 60.1 хувийн биелэлттэй үнэлэгдлээ.

“Монгол Улсын хөгжлийн 2024 оны төлөвлөгөө”-нд тусгагдсан 194 төсөл, арга хэмжээнээс 39 төсөл, арга хэмжээ үр дүнтэй буюу “100.0” хувийн хэрэгжилттэй, 61 төсөл, арга хэмжээ тодорхой үр дүнд хүрсэн буюу “70-99” хувийн хэрэгжилттэй, 79 төсөл, арга хэмжээ, эрчимжүүлэх шаардлагатай буюу “30-69” хувийн хэрэгжилттэй, 15 төсөл, арга хэмжээ, үр дүнгүй буюу “0-29” хувийн хэрэгжилттэй тус тус үнэлэгдлээ.

Төлөвлөгөөний биелэлтийг тэргүүлэх чиглэл болон хэрэгжилтийн хувиар нэгтгэн харуулбал:

Хүснэгт 2. “Монгол Улсын хөгжлийн 2024 оны төлөвлөгөө”-нд тусгагдсан төсөл, арга хэмжээний хэрэгжилт

дд	Тэргүүлэх чиглэл	Төсөл, арга хэмжээ	Шалгуур үзүүлэлт	100	99-91	90	89-71	70	69-51	50	49-31	30	29-1	0	Дундаж үнэлгээ, %
				үр дүнтэй	тодорхой үр дүнд хүрсэн			эрчимжүүлэх шаардлагатай			үр дүнгүй				
1	Экспортыг нэмэгдүүлнэ	23	23	2	0	3	0	3	0	0	0	12	1	2	45.7
2	Хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлнэ	52	52	11	0	9	0	5	0	6	0	15	0	6	57.9
3	Хүний хөгжлийн үзүүлэлтийг сайжруулна.	28	37	8	1	7	2	1	1	1	0	4	1	2	71.3
4	Аялал жуулчлалыг хөгжүүлнэ.	35	35	4	0	4	0	5	0	0	0	21	0	1	49.7

5	Хүнсний хангамж, аюулгүй байдлыг сайжруулна.	5	5	0	0	4	0	0	0	0	0	1	0	0	78.0
6	Улаанбаатар хотын түгжрэл, агаарын бохирдлыг бууруулна.	23	23	3	0	2	0	4	0	4	0	8	1	1	53.4
7	Засаглалын үзүүлэлтийг сайжруулна.	20	20	5	0	6	0	4	0	3	0	2	0	0	76.5
8	Ногоон хөгжлийг дэмжинэ.	8	10	6	0	0	0	1	0	1	0	0	0	0	90.0
Нийт		194	205	13	5	9	2	30	9	24	6	25	7	64	60.1
<i>Нийт дүнд эзлэх хувь</i>															

3.2.1. “Экспортыг нэмэгдүүлэх тэргүүлэх чиглэлийн”-ын хүрээнд ТЕЗ-ийн үр дүн тус бүрээр:

“Экспортыг нэмэгдүүлэх тэргүүлэх чиглэл”-ийн 4 Төсвийн ерөнхийлөн захирагчийн үр дүнгийн хүрээнд 23 төсөл, арга хэмжээний хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийхэд дунджаар 45.7 хувьтай, “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам”-ын 6.2.3.3-т заасны дагуу “эрчимжүүлэх шаардлагатай” байна.

Төсвийн ерөнхийлөн захирагчийн үр дүн тус бүрээр хэрэгжилтийг авч үзэхэд, Ачаа тээвэрлэх хүчин чадлыг нэмэгдүүлэх хүрээнд 11 төсөл, арга хэмжээний хэрэгжилт дунджаар 37.3 хувьтай, Боомтын хүчин чадлыг нэмэгдүүлэх хүрээнд 5 төсөл, арга хэмжээний хэрэгжилт дунджаар 50.0 хувьтай, Хөдөө аж ахуйн гаралтай бүтээгдэхүүний экспортыг нэмэгдүүлэх хүрээнд 5 төсөл, арга хэмжээний хэрэгжилт 58.0 хувьтай, Гадаад худалдааг хөнгөвчлөх хүрээнд 2 төсөл, арга хэмжээний хэрэгжилт дунджаар 50.0 хувьтай байна.

Хүснэгт 3. “Экспортыг нэмэгдүүлэх” бодлогын тэргүүлэх чиглэлийн ТЕЗ-ийн үр дүнгийн үнэлгээ

дд	ТЕЗ-ийн үр дүн	Зорилт	Шалгуур	Хэрэгжилтийн хувь											Дундаж үнэлгээ
				100	99-91	90	89-71	70	69-51	50	31-49	30	1-29	0	
1	Ачаа тээвэрлэх хүчин чадлыг нэмэгдүүлнэ	11	11	-	-	1	-	1	-	-	-	8	1	-	37.3
2	Боомтын хүчин чадлыг нэмэгдүүлнэ	5	5	1	-	1	-	-	-	-	-	2	-	1	50.0
3	Хөдөө аж ахуйн гаралтай бүтээгдэхүүний экспортыг нэмэгдүүлнэ	5	5	1	-	1	-	1	-	-	-	1	-	1	58.0
4	Гадаад худалдааг хөнгөвчилнэ	2	2	-	-	-	-	-	-	-	-	-	-	2	50.0
Нийт		23	23	2	0	3	0	2	0	0	0	11	1	4	45.7

3.2.2. “Хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх тэргүүлэх чиглэл”-ийн хүрээнд ТЕЗ-ийн үр дүн тус бүрээр:

“Хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх тэргүүлэх чиглэл”-ийн хүрээнд 52 төсөл, арга хэмжээний хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийхэд дунджаар 57.9 хувьтай, “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам”-ын 6.2.3.3-т заасны дагуу “эрчимжүүлэх шаардлагатай” байна.

Төсвийн ерөнхийлөн захирагчийн үр дүн тус бүрээр хэрэгжилтийг авч үзэхэд, Хөрөнгө оруулалт хийх, бизнесийн үйл ажиллагаа эрхлэх таатай орчныг бүрдүүлэх

хүрээнд 9 төсөл, арга хэмжээний хэрэгжилт дунджаар 73.3 хувьтай, Уул уурхайн салбар дахь хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх хүрээнд нийт 16 төсөл, арга хэмжээний хэрэгжилт дунджаар 48.8 хувьтай, Эрчим хүчний дотоодын хэрэгцээг бүрэн хангаж, эрчим хүч экспортлох суурь нөхцөлийг бүрдүүлэх хүрээнд 18 төсөл, арга хэмжээний хэрэгжилт дунджаар 57.8 хувьтай, Соёлын салбарыг эдийн засгийн эргэлтэд оруулах хүрээнд 7 төсөл, арга хэмжээний хэрэгжилт 58.6 хувьтай, Чөлөөт бүсүүдийг эдийн засгийн эргэлтэд оруулж, хөрөнгө оруулалт татах хүрээнд 2 төсөл, арга хэмжээний биелэлт 60.0 хувьтай байна.

Хүснэгт 4. “Хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх” бодлогын тэргүүлэх чиглэлийн ТЕЗ-ийн үр дүнгийн үнэлгээ

дд	ТЕЗ-ийн үр дүн	Төсөл, арга хэмжээ	Шалгуур үзүүлэлт	Хэрэгжилтийн хувь										Дундаж үнэлгээ, %		
				100	99-91	90	89-71	70	69-51	50	49-31	30	29-1		0	
1	Хөрөнгө оруулалт хийх, бизнесийн үйл ажиллагаа эрхлэх таатай орчныг бүрдүүлнэ.	9	5	2	-	4	-	1	-	-	-	1	-	-	73.3	
2	Уул уурхайн салбар дахь хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлнэ.	16	13	1	-	3	-	-	-	4	-	7	-	1	48.8	
3	Эрчим хүчний дотоодын хэрэгцээг бүрэн хангаж, эрчим хүч экспортлох суурь нөхцөлийг бүрдүүлнэ.	18	18	6	-	1	-	3	-	1	-	3	-	4	57.8	
4	Соёлын салбарыг эдийн засгийн эргэлтэд оруулна.	7	7	2	-	1	-	-	-	-	-	4	-	-	58.6	
5	Чөлөөт бүсүүдийг эдийн засгийн эргэлтэд оруулж, хөрөнгө оруулалт татна.	2	2	-	-	-	-	1	-	1	-	-	-	-	60.0	
Нийт		52	45	4	1	4	1	1	4	2	6	-	5	3	12	57.9

3.2.3 “Хүний хөгжлийн үзүүлэлтийг сайжруулах тэргүүлэх чиглэл”-ийн хүрээнд ТЕЗ-ийн үр дүн тус бүрээр:

“Хүний хөгжлийн үзүүлэлтийг сайжруулах тэргүүлэх чиглэл”-ийн хүрээнд 28 төсөл, арга хэмжээний хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийхэд дунджаар 71.3 хувьтай, “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам”-ын 6.2.3.2-т заасны дагуу “тодорхой үр дүнд хүрсэн” байна.

Төсвийн ерөнхийлөн захирагчийн үр дүн тус бүрээр хэрэгжилтийг авч үзэхэд, Боловсролын салбарын чанар, хүртээмжийг сайжруулах хүрээнд 12 төсөл, арга хэмжээний хэрэгжилт дунджаар 79.5 хувьтай, Нийгмийн баталгааг сайжруулах хүрээнд 4 төсөл, арга хэмжээний хэрэгжилт дунджаар 90.0 хувьтай, Өвчлөл, нас баралтыг бууруулах хүрээнд 12 төсөл, арга хэмжээний хэрэгжилт 56.8 хувьтай байна.

Хүснэгт 5. “Хүний хөгжлийн үзүүлэлтийг сайжруулах” бодлогын тэргүүлэх чиглэлийн ТЕЗ-ийн үр дүнгийн үнэлгээ

дд	ТЕЗ-ийн үр дүн	Төсөл, арга хэмжээ	Шалгуур үзүүлэлт	Хэрэгжилтийн хувь										Дундаж үнэлгээ, %	
				100	99-91	90	89-71	70	69-51	50	49-31	30	29-1		0
1	Боловсролын салбарын чанар, хүртээмжийг сайжруулна.	12	20	6	1	-	1	1	1	-	-	1	1	-	79.5
2	Нийгмийн баталгааг сайжруулна.	4	4	-	-	4	-	-	-	-	-	-	-	-	90.0
3	Өвчлөл, нас баралтыг бууруулна	12	13	2	-	3	1	-	-	1	-	3	-	2	56.8
Нийт		28	37												71.3

3.2.4 “Аялал жуулчлалыг хөгжүүлэх тэргүүлэх чиглэл”-ийн хүрээнд ТЕЗ-ийн үр дүн тус бүрээр:

“Аялал жуулчлалыг хөгжүүлэх тэргүүлэх чиглэл”-ийн хүрээнд 35 төсөл, арга хэмжээний хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийхэд дунджаар 49.7 хувьтай, “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам”-ын 6.2.3.3-т заасны дагуу “эрчимжүүлэх шаардлагатай” байна.

Төсвийн ерөнхийлөн захирагчийн үр дүн тус бүрээр хэрэгжилтийг авч үзэхэд, Жуулчдад зориулсан бүтээгдэхүүний нэр төрлийг нэмэгдүүлэх хүрээнд 5 төсөл, арга хэмжээний хэрэгжилт дунджаар 52.0 хувьтай, Агаарын тээврээр зорчих жуулчдыг нэмэгдүүлэх хүрээнд 5 төсөл, арга хэмжээний хэрэгжилт дунджаар 42.0 хувьтай, Аялал жуулчлалын бүс нутгийн авто замын дэд бүтцийн чанар, хүртээмжийг нэмэгдүүлэх хүрээнд 25 төсөл, арга хэмжээний хэрэгжилт 50.8 хувьтай байна.

Хүснэгт 6. “Аялал жуулчлалыг хөгжүүлэх” бодлогын тэргүүлэх чиглэлийн ТЕЗ-ийн үр дүнгийн үнэлгээ

дд	ТЕЗ-ийн үр дүн	Төсөл, арга хэмжээ	Шалгуур үзүүлэлт	Хэрэгжилтийн хувь										Дундаж үнэлгээ, %	
				100	99-91	90	89-71	70	69-51	50	49-31	30	29-1		0
1	Жуулчдад зориулсан бүтээгдэхүүний нэр төрлийг нэмэгдүүлнэ.	5	5	2	-	-	-	-	-	-	-	2	-	1	52.0
2	Агаарын тээврээр зорчих жуулчдыг нэмэгдүүлнэ.	5	5	-	-	1	-	-	-	-	-	4	-	-	42.0
3	Аялал жуулчлалын бүс нутгийн авто замын дэд бүтцийн чанар, хүртээмжийг нэмэгдүүлнэ.	25	25	2	-	3	-	5	-	-	-	15	-	-	50.8
Нийт		35	35	4	-	4	-	5	-	-	-	21	-	1	49.7

3.2.5 “Хүнсний хангамж, аюулгүй байдлыг сайжруулах тэргүүлэх чиглэл”-ийн хүрээнд ТЕЗ-ийн үр дүн тус бүрээр:

“Хүнсний хангамж, аюулгүй байдлыг сайжруулах тэргүүлэх чиглэл”-ийн хүрээнд 5 төсөл, арга хэмжээний хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийхэд дунджаар 78.0 хувьтай, “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам”-ын 6.2.3.2-т заасны дагуу “тодорхой үр дүнд хүрсэн” байна.

Хүснэгт 7. “Хүнсний хангамж, аюулгүй байдлыг сайжруулах” бодлогын тэргүүлэх чиглэлийн ТЕЗ-ийн үр дүнгийн үнэлгээ

дд	ТЕЗ-ийн үр дүн	Төсөл, арга хэмжээ	Шалгуур үзүүлэлт	Хэрэгжилтийн хувь										Дундаж үнэлгээ, %	
				100	99-91	90	89-71	70	69-51	50	49-31	30	29-1		0
1	Хүн амын хүнсний гол нэрийн бүтээгдэхүүний дотоодын хангамжийг нэмэгдүүлнэ.	5	5	-	-	4	-	-	-	-	-	1	-	-	78.0
Нийт		5	5	-	-	4	-	-	-	-	-	1	-	-	78.0

3.2.6 “Улаанбаатар хотын түгжрэл, агаарын бохирдлыг бууруулах тэргүүлэх чиглэл”-ийн хүрээнд ТЕЗ-ийн үр дүн тус бүрээр:

“Улаанбаатар хотын түгжрэл, агаарын бохирдлыг бууруулах тэргүүлэх чиглэл”-ийн хүрээнд 23 төсөл, арга хэмжээний хэрэгжилтэд хяналт-шинжилгээ,

үнэлгээ хийхэд дунджаар 53.4 хувьтай, “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам”-ын 6.2.3.3-т заасны дагуу “эрчимжүүлэх шаардлагатай” байна.

Төсвийн ерөнхийлөн захирагчийн үр дүн тус бүрээр хэрэгжилтийг авч үзэхэд, Улаанбаатар хотын зорчих дэд бүтцийн хүртээмжийг сайжруулах хүрээнд 15 төсөл, арга хэмжээний хэрэгжилт дунджаар 39.2 хувьтай, Агаарын бохирдлыг бууруулах дэд бүтцийн чанар хүртээмжийг нэмэгдүүлэх хүрээнд 8 төсөл, арга хэмжээний хэрэгжилт дунджаар 80.0 хувьтай байна.

Хүснэгт 8. “Улаанбаатар хотын түгжрэл, агаарын бохирдлыг бууруулах” бодлогын тэргүүлэх чиглэлийн ТЕЗ-ийн үр дүнгийн үнэлгээ

дд	ТЕЗ-ийн үр дүн	Төсөл, арга хэмжээ	Шалгуур үзүүлэлт	Хэрэгжилтийн хувь										Дундаж үнэлгээ, %	
				100	99-91	90	89-71	70	69-51	50	49-31	30	29-1		0
1	Улаанбаатар хотын зорчих дэд бүтцийн хүртээмжийг сайжруулна.	15	15	1	-	-	-	1	-	3	-	8	1	1	39.2
2	Агаарын бохирдлыг бууруулах дэд бүтцийн чанар хүртээмжийг нэмэгдүүлнэ.	8	8	2	-	2	-	3	-	1	-	-	-	-	80.0
Нийт		23	23	2	1	1	-	1	1	6	1	7	-	3	53.4

3.2.7 “Засаглалын үзүүлэлтийг сайжруулах тэргүүлэх чиглэл”-ийн хүрээнд ТЕЗ-ийн үр дүн тус бүрээр:

“Засаглалын үзүүлэлтийг сайжруулах тэргүүлэх чиглэл”-ийн хүрээнд 5 төсөл, арга хэмжээний хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийхэд дунджаар 76.5 хувьтай, “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам”-ын 6.2.3.2-т заасны дагуу “тодорхой үр дүнд хүрсэн” байна.

Төсвийн ерөнхийлөн захирагчийн үр дүн тус бүрээр хэрэгжилтийг авч үзэхэд, Авлигын үзүүлэлтийг сайжруулах хүрээнд 2 төсөл, арга хэмжээний хэрэгжилт дунджаар 100.0 хувьтай, Төрийн бүтээмжийг дээшлүүлэх 10 арга хэмжээний хэрэгжилт дунджаар 68.0 хувьтай, Хүний эрхийн зөрчлийг бууруулах 2 арга хэмжээний дундаж 60.0 хувьтай, Батлан хамгаалах чадавхыг бэхжүүлэх 3 арга хэмжээний дундаж 80.0 хувьтай, Шүүх шинжилгээний дүгнэлтийн чанарыг дээшлүүлэх 3 арга хэмжээний дундаж 96.7 хувьтай тус тус үнэлэгдсэн байна.

Хүснэгт 9. “Засаглалын үзүүлэлтийг сайжруулах” бодлогын тэргүүлэх чиглэлийн ТЕЗ-ийн үр дүнгийн үнэлгээ

дд	ТЕЗ-ийн үр дүн	Төсөл, арга хэмжээ	Шалгуур үзүүлэлт	Хэрэгжилтийн хувь										Дундаж үнэлгээ, %	
				100	99-91	90	89-71	70	69-51	50	49-31	30	29-1		0
1	Авлигын үзүүлэлтийг сайжруулна.	2	2	2	-	-	-	-	-	-	-	-	-	-	100.0
2	Төрийн бүтээмжийг дээшлүүлнэ.	10	10	-	-	2	-	3	-	2	-	1	-	2	65.0
3	Хүний эрхийн зөрчлийг бууруулна.	2	2	-	-	1	-	-	-	-	-	1	-	-	60.0
4	Батлан хамгаалах чадавхыг бэхжүүлнэ.	3	3	1	-	1	-	-	-	1	-	-	-	-	80.0
5	Шүүх шинжилгээний дүгнэлтийн чанарыг дээшлүүлнэ.	3	3	2	-	1	-	-	-	-	-	-	-	-	96.7
Нийт		20	20	5	-	5	-	3	-	3	-	2	-	2	76.5

3.2.8 “Ногоон хөгжлийг дэмжих тэргүүлэх чиглэл”-ийн хүрээнд ТЕЗ-ийн үр дүн тус бүрээр:

“Ногоон хөгжлийг дэмжих тэргүүлэх чиглэл”-ийн хүрээнд 8 төсөл, арга хэмжээний хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийхэд дунджаар 90.0 хувьтай, “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам”-ын 6.2.3.2-т заасны дагуу “тодорхой үр дүнд хүрсэн” байна.

Хүснэгт 10. “Ногоон хөгжлийг дэмжих” бодлогын тэргүүлэх чиглэлийн ТЕЗ-ийн үр дүнгийн үнэлгээ

дд	ТЕЗ-ийн үр дүн	Төсөл, арга хэмжээ	Шалгуур үзүүлэлт	Хэрэгжилтийн хувь											Дундаж үнэлгээ, %
				100	99-91	90	89-71	70	69-51	50	49-31	30	29-1	0	
1	Байгаль орчны тогтвортой байдлыг хадгална.	8	10	6	-	-	-	1	-	1	-	-	-	-	90
Нийт				8	10	6	-	-	-	1	-	1	-	-	90.0

Төсвийн ерөнхийлөн захирагчийн үр дүнд туссан арга хэмжээг үндсэн хэрэгжүүлэгч байгууллага тус бүрээр авч үзвэл:

Хүснэгт 11. Үнэлгээ яамд, байгууллагаар

дд	Үндсэн хариуцагч байгууллага	Төсөл, арга хэмжээ	Шалгуур үзүүлэлт	Хэрэгжилтийн хувь											Дундаж үнэлгээ, %
				100	99-91	90	89-71	70	69-51	50	49-31	30	29-1	0	
				Үр дүнтэй	Тодорхой үр дүнд хүрсэн			Эрчимжүүлэх шаардлагатай			Үр дүнгүй				
1	АУЭБЯ	14	14	1		1				4		7		1	42.9
2	БОУАӨЯ	7	9	4		1		1		1					87.1
3	БоЯ	12	16	6		1		2			1	1	1		77.9
4	БХЯ	2	2			1				1					70.0
5	ГБХНХЯ	4	4			4									90.0
6	ГЗБГЗЗЕГ	2	2					2							70.0
7	ГХЯ	3	3	1		1		1							86.7
8	ЗГХЭГ	2	2			1								1	45
9	ЗТЯ	46	46	4		4		6				31	1		46.1
10	МБ	1	1									1			30.0
11	НЗДТГ	17	17	2		1		3		4		5	1	1	51.6
12	СЗХ	2	2	1		1									95.0
13	ССАЖЗЯ	11	11	2		3				1		4		1	58.2
14	ХББОСЯ	6	6	2		1		3							83.3
15	ХЗДХЯ	9	9	5		2				1		1			84.4
16	ХХААХҮЯ	8	8	1		5						1		1	72.5
17	ЦХИХХЯ	3	3			1				1		1			56.7
18	Шадар сайд С.Амарсайхан	5	5			1		1		1		2			54.0
19	Шадар сайд Т.Доржханд	2	2											2	0.0
20	ЭЗХЯ	7	11	2	1	3		1							90.5
21	ЭМЯ	9	10	2		2						3		2	52.2
22	ЭХЯ	18	18	6		2		2		1		3		4	58.9
23	БСҮХ	3	3									3			30.0
24	ТӨБЗГ	1	1					1							70.0
Нийт		194	205	39	1	36	0	23	0	15	1	63	3	13	

Монгол Улсын хөгжлийн 2024 оны төлөвлөгөөнд туссан 24 төсвийн ерөнхийлөн захирагчийн үр дүн, 53 хөтөлбөрийн үр дүн, 194 төсөл, арга хэмжээний үнэлгээний дунджийг хүснэгтээр харуулбал:

Д Д	МУХЖТ-ний 2024 оны хэрэгжилт	Төсөл, арга хэмжээ	Шалгуур үзүүлэлт	Хэрэгжилтийн хувь											Дундаж үнэлгээ, %
				100	99-91	90	89-71	70	69-51	50	49-31	30	29-1	0	
1	Төсвийн ерөнхийлөн	24	29	11	-	-	1	2	-	-	1	-	3	11	54.6

	захирагчийн үрдүн														
2	Хөтөлбөрийн үрдүн.	53	63	6	2	9	4	12	0	5	0	7	0	8	59.8
3	Төсөл арга хэмжээ	194	205	39	1	35	2	23	1	15	0	63	3	12	60.1

3.3. Санхүүжилтийн гүйцэтгэл

“Монгол Улсын хөгжлийн 2024 оны төлөвлөгөө”-нд 195 төсөл, арга хэмжээ, 205 шалгуур үзүүлэлтийг 13.994.7 сая төгрөгөөр санхүүжүүлэхээр төлөвлөсөн бөгөөд гүйцэтгэлээр 5.099.9 сая төгрөгийн санхүүжилтийг хийсэн нь нийт төлөвлөсөн дүнгийн 36.4 хувийг эзэлж байна.

Нийт 194 төсөл, арга хэмжээнээс санхүүжүүлэх эх үүсвэр, мөнгөн дүнг төлөвлөгөөнд тусгаагүй 9 төсөл, арга хэмжээ байна. Харин гүйцэтгэлээр 96 төсөл, арга хэмжээ 2024 оны жилийн эцэст санхүүжилт авсан байна.

“Монгол Улсын хөгжлийн 2024 оны төлөвлөгөө”-ний 194 төсөл, арга хэмжээний санхүүжилтийн гүйцэтгэлийг эх үүсвэр тус бүрээр авч үзлээ.

“Монгол Улсын хөгжлийн 2024 оны төлөвлөгөө”-нд:

- Улсын төсвийн хөрөнгөөр 120 төсөл, арга хэмжээнд 2.224.6 сая төгрөг төлөвлөснөөс гүйцэтгэлээр 67 төсөл, арга хэмжээнд 2.652.4 сая төгрөг;

- Улсын төсөв, гадаадын зээлээр 4 төсөл, арга хэмжээнд 441.4 тэрбум төгрөг төлөвлөж санхүүжилт хийгдээгүй;

- Улсын төсөв, гадаад дотоодын хөрөнгө оруулалтаар 1 шалгуур үзүүлэлтэд 83.7 тэрбум төгрөг төлөвлөснөөс санхүүжилт хийгдээгүй;

- Улсын төсөв, гадаадын тусламжаар 1 төсөл, арга хэмжээнд 65.3 тэрбум төгрөгийг төлөвлөж санхүүжилт хийгдээгүй;

- Гадаадын зээл, тусламжаар 23 төсөл, арга хэмжээнд 1.386.8 сая төгрөгийг төлөвлөж гүйцэтгэлээр 13 төсөл, арга хэмжээнд 1.003.9 сая төгрөг;

- Төр-хувийн хэвшлийн түншлэлээр 6 төсөл, арга хэмжээнд 4.520.7 сая төгрөгийг төлөвлөснөөс гүйцэтгэлээр 1 төсөл арга хэмжээнд 160.0 тэрбум төгрөг;

- Орон нутгийн төсвөөр 16 төсөл, арга хэмжээнд 99.0 тэрбум төгрөгийг төлөвлөснөөс 6 төсөл арга хэмжээнд 652.3 тэрбум төгрөг;

- Орон нутгийн төсөв, гадаадын зээлээр 2 төсөл, арга хэмжээнд 148.0 тэрбум төгрөгийг төлөвлөснөөс санхүүжилт хийгдээгүй;

- Гадаад, дотоодын хөрөнгө оруулалтаар 9 төсөл, арга хэмжээнд 3.436.0 сая төгрөгийг төлөвлөж гүйцэтгэлээр 5 төсөл, арга хэмжээнд 474,162.0 сая төгрөг;

- Бусад эх үүсвэрээр 12 төсөл, арга хэмжээнд 1,589.0 сая төгрөгийг төлөвлөж гүйцэтгэлээр 3 төсөл, арга хэмжээнд 157.1 тэрбум төгрөгийг тус тус зарцуулсан байна.

-Эх үүсвэр шийдэгдээгүй 1 төсөл арга хэмжээ гүйцэтгэлээр 32.0 тэрбум төгрөг гарсан байна.

Хүснэгт 12. Төсөл, арга хэмжээний санхүүжилтийн эх үүсвэр

дд	Санхүүжилтийн эх үүсвэр	Төлөвлөсөн		Гүйцэтгэл	
		Төсөл, арга хэмжээ	Төлөвлөсөн /сая төгрөг/	Төсөл, арга хэмжээ	Зарцуулсан /сая төгрөг/
1	Улсын төсөв	120	2,224,600.58	67	2,652,424.14

2	Улсын төсөв, гадаадын зээл	4	441,377.65		
3	Улсын төсөв, гадаад, дотоодын хөрөнгө оруулалт	1	83,679.60		
4	Улсын төсөв, гадаадын тусламж	1	65,376.90		
5	Гадаадын зээл, тусламж	23	1,386,850.28	13	1,003,966.48
6	Төр-хувийн хэвшлийн түншлэл	6	4,520,787.53	1	160,000
7	Орон нутгийн төсөв	16	99,000.00	6	652,286.1
8	Орон нутгийн төсөв, гадаадын зээл	2	147,985.80		
9	Гадаад, дотоодын хөрөнгө оруулалт	9	3,435,957.60	5	474,162.60
10	Бусад эх үүсвэр	12	1,589,036.56	3	157,059.52
11	Эх үүсвэр тавьж өгөөгүй	-	-	1	32.00
Нийт		194	13,994,652.50	96	5,099,930.84

Төлөвлөгөөнд тусгагдсан 194 төсөл, арга хэмжээгээр санхүүжилтийн гүйцэтгэлийг харвал 10 төрлийн эх үүсвэрээс 13.994.7 сая төгрөгийн санхүүжилтийг төлөвлөснөөс 2024 оны жилийн эцсийн гүйцэтгэлээр 7 төрлийн 96 төсөл, арга хэмжээнд 5.099.9 сая төгрөгөөр санхүүжсэн байна.

Гүйцэтгэлээр улсын төсвөөс 67 төсөл, арга хэмжээ нийт зарцуулсан санхүүжилтийн 52 хувь, гадаадын зээл тусламжаар 13 төсөл, арга хэмжээ нийт зарцуулсан санхүүжилтийн 19.7 хувь, төр хувийн хэвшлийн түншлэлээр 1 төсөл арга хэмжээ нийт санхүүжилтийн 3.1 хувь, орон нутгийн төсвөөр 6 төсөл арга хэмжээ нийт санхүүжилтийн 12.8 хувь, гадаад дотоодын хөрөнгө оруулалтаар 5 төсөл арга хэмжээ нийт санхүүжилтийн 9.3 хувь, бусад эх үүсвэрээр 3 төсөл арга хэмжээ нийт санхүүжилтийн 3.1 хувь, эх үүсвэр тавьж өгөөгүй 1 төсөл арга хэмжээ нийт санхүүжилтийн 0.0006 хувийг тус тус эзэлж байна.

Санхүүжилтийн гүйцэтгэлийн хувьд төрийн захиргааны төв байгууллагууд болон холбогдох байгууллагууд мөнгөн дүнг сая төгрөгөөр илэрхийлэхээр заасан боловч тэрбум төгрөг, мянган төгрөг, төгрөг эсхүл орон алдсан гэх мэт нарийвчлалгүй буруу тайлагнах, зарцуулсан санхүүжилтийн эх үүсвэр тодорхой бус эсхүл дурдаагүй байсныг тодруулж тайлагнасан.

Дөрөв. Дүгнэлт

Монгол Улсын 2024 онд баримтлах бодлогын тэргүүлэх чиглэлийн хэрэгжилт:

Монгол Улсын 2024 онд баримтлах бодлогын 8 тэргүүлэх чиглэлийн хүрээнд хэрэгжүүлэх 23 үндсэн зорилтын хэрэгжилт 2024 оны жилийн эцсийн байдлаар 70.8 хувь буюу Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журамд заасны дагуу “тодорхой үр дүнд хүрсэн” гэж үнэлэгдлээ.

Монгол Улсын хөгжлийн 2024 оны төлөвлөгөөний хэрэгжилт:

“Монгол Улсын хөгжлийн 2024 оны төлөвлөгөө”-нд 8 тэргүүлэх чиглэлийн хүрээнд 194 төсөл арга хэмжээ, 205 шалгуур үзүүлэлт тусгагдсанаас 2024 оны жилийн эцсийн байдлаар төсөл, арга хэмжээний хэрэгжилт 60.1 хувь буюу “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт болон захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам”-ын 6.2.3-д заасан ангилалд шилжүүлэн тооцвол, нийт батлагдсан төсөл, арга хэмжээний 20.1 хувь буюу 39 төсөл арга хэмжээ үр дүнтэй, 19.5 хувь буюу 38 төсөл, арга хэмжээ

тодорхой үр дүнд хүрсэн, 52.5 хувь буюу 102 арга хэмжээ эрчимжүүлэх шаардлагатай, 7.7 хувь буюу 15 төсөл, арга хэмжээ үр дүнгүй үнэлэгдлээ.

“Монгол Улсын хөгжлийн 2024 оны төлөвлөгөө”-нд 194 төсөл, арга хэмжээг 13.9 их наяд төгрөгөөр санхүүжүүлэхээр төлөвлөж, гүйцэтгэлээр 5.1 их наяд төгрөгийг зарцуулсан нь нийт төсөвлөсөн дүнгийн 36.7 хувийг эзэлж байна.

Монгол Улсын хөгжлийн 2024 оны төлөвлөгөөний хяналт-шинжилгээ, үнэлгээний үзүүлэлтийн хэрэгжилт:

- Төлөвлөгөөний дагуу батлагдсан 100 шалгуур үзүүлэлтүүдээс 2024 оны жилийн эцсийн байдлаар үнэлэх боломжтой 91 шалгуур үзүүлэлт, үнэлэх боломжгүй буюу хэрэгжилт гараагүй 9 шалгуур үзүүлэлт байсан ба нийт шалгуур үзүүлэлтүүдийн дундаж үнэлгээ **53.3** хувь буюу Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журамд заасны дагуу “эрчимжүүлэх шаардлагатай” гэж үнэлэгдлээ. Шалгуур үзүүлэлтийн хэрэгжилтийн үнэлгээ буурахад тайлант үеийн шалгуур үзүүлэлтүүд суурь түвшнээс буурсан байгаа нь голлон нөлөөлөв.

- Доорх хүснэгтэд шалгуур үзүүлэлтүүдийг төсвийн ерөнхийлөн захирагчийн үр дүнгийн болон хөтөлбөрийн үр дүнгийн дундаж үнэлгээний хувь тус бүрээр харуулав.

Хүснэгт 13. Хяналт-шинжилгээ, үнэлгээний үзүүлэлтийн хэрэгжилтийн үнэлгээ

дд	ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ ҮЗҮҮЛЭЛТ	Төсөл, арга	Шалгуур үзүүлэлт	Хэрэгжилтийн хувь										Дундаж үнэлгээ, %	
				100	99-91	90	89-71	70	69-51	50	49-31	30	29-1		0
1	Тэргүүлэх чиглэлийн үр дүн	8	8	3							1		2	2	56.1
1	Төсвийн ерөнхийлөн захирагчийн үр дүн	24	29	11	-	-	1	2	-	-	1	-	3	11	54.6
2	Хөтөлбөрийн үр дүн.	53	63	20	2		4	1	3	1	4		4	24	52.4
	Нийт	100	100	34	2	0	5	3	3	1	6	0	9	37	53.3

“Монгол Улсын хөгжлийн 2024 оны төлөвлөгөө” нь суурь болон зорилтот түвшин бүхий хяналт-шинжилгээ, үнэлгээний шалгуур үзүүлэлттэй батлагдсан бөгөөд тайлан ирүүлсэн байгууллагууд журмын 6.2.2-т заасан аргачлалыг ашигласан байна.

Тав. Санал

Монгол Улсын хөгжлийн 2024 оны төлөвлөгөөний хэрэгжилтэд хийсэн хяналт шинжилгээ, үнэлгээний дүнг үндэслэн цаашид Засгийн газрын гишүүд, Засгийн газрын агентлагийн дарга, нийслэлийн Засаг дарга нар дараах асуудалд анхаарч ажиллах шаардлагатай байна. Үүнд:

Төлөвлөлтийг сайжруулах талаар:

- Улсын хөгжлийн жилийн төлөвлөгөөг боловсруулахад тэргүүлэх чиглэлийг оновчтой тодорхойлж, төлөвлөгөө, шалгуур үзүүлэлттэй нягт уялдуулах, мөн тэргүүлэх чиглэлийг хариуцах байгууллагыг төлөвлөгөөнд тодорхой тусгаж, дараа жилийн богино хугацааны бодлогын баримт бичгийн төлөвлөлтөд анхаарах;

- Улсын хөгжлийн жилийн төлөвлөгөөний төсөл, арга хэмжээг боловсруулахдаа тухайн арга хэмжээг хэрэгжүүлэх үндсэн болон хамтран хариуцагч байгууллагуудын оролцоог чиг үүргийн дагуу нарийвчлан тооцож тусгах;

- Төсөл, арга хэмжээ, шалгуур үзүүлэлт бүрд нэг байгууллагыг үндсэн хариуцагчаар төлөвлөж, бусад хамтран хариуцагч байгууллагуудыг нэгдсэн удирдлага, зохион байгуулалтаар хангаж, эргэх уялдаа холбоог сайжруулах.

- Улсын хөгжлийн жилийн төлөвлөгөөнд туссан арга хэмжээний санхүүжилтийн эх үүсвэрийг шийдвэрлүүлж, тухайн жилд төлөвлөсөн арга хэмжээг бүрэн хэрэгжүүлэхэд анхаарах.

Тайлагналыг сайжруулах талаар:

- Тайланд зарцуулсан хөрөнгийн хэмжээ, эх үүсвэрийг тодорхой тусгаж, нотлох баримтыг хавсарган, иж бүрэн тайлагнах, мөн санхүүжилтийн гүйцэтгэлийн дүнг сайтар нягталж, зарцуулалтыг бүрэн гүйцэд тайлагнаж байх;

- Бодлогын баримт бичигт хэрэгжүүлэхээр төлөвлөсөн төсөл, арга хэмжээний хүрээнд хэрэгжилтийг бүрэн тайлагнах; (тухайн төлөвлөсөн төсөл арга хэмжээний явц, үйл ажиллагаа бус үр дүнг тайлагнах)

Улсын хөгжлийн жилийн төлөвлөгөөний хэрэгжилтийг тайлагнаж, хяналт-шинжилгээ, үнэлгээ хийхдээ хууль тогтоомж батлагдсанаар эсхүл төсөл арга хэмжээ хэрэгжсэнээр нийгэм, эдийн засагт ямар нөлөө, эерэг өөрчлөлт бий болсныг үнэлж тооцдог байх;

- Тайлангийн үг, үсэг, утга найруулгын алдаанаас гадна 2000 тэмдэгтэд багтаан шалгуур үзүүлэлт, зорилтод түвшинг харгалзан товч, тодорхой тайлагнах (цахим системд дэлгэрэнгүй тайлбарлаж, нотлох баримтыг хавсаргах, мэргэжлийн болон гадаад товчилсон үг хэллэгийг тайлбартайгаар ирүүлэх)

- Төслийн явц, үйл ажиллагаатай холбоотой хяналт-шалгалт, мониторинг хийсэн бол хяналт-шинжилгээ, үнэлгээний тайланд мониторингийн тайланг хавсаргаж ирүүлэх, мөн талуудын ажил гүйцэтгэх гэрээнд заасан гүйцэтгэлийн дагуу олгосон санхүүжилт, гүйцэтгэлийн тайланг ирүүлдэг байх;

- Төлөвлөгөөнд үндсэн хариуцагчаар батлагдсан бол хамтран хариуцагч байгууллага тус бүрээс хэрэгжилтийн тайлан болон санхүүжилтийн гүйцэтгэлийг авч нэгтгэн тайлагнах;

- Санхүүжилтийн гүйцэтгэлийн дүнг гадаад валютаар илэрхийлэх, сая төгрөгөөр илэрхийлэхээр заасан байхад тэрбум төгрөг, мянган төгрөгөөр оронгийн нарийвчлалгүй буруу тайлагнах, зарим төсөл, арга хэмжээний хувьд тухайн онд зарцуулсан хөрөнгийг өмнөх онуудад зарцуулсан хөрөнгөтэй хамт өссөн дүнгээр тайлагнах, эх үүсвэрийг дурдаагүй байх, үндсэн хариуцагчийн тайлагнасан санхүүжилтийн дүнд хамтран хариуцагчийн гүйцэтгэлийн дүн тусгагдсан эсэх нь тодорхойгүй зэрэг нийтлэг дутагдлыг залруулж, яамд, байгууллагууд хоорондын ажлын уялдааг сайжруулах;

ЭДИЙН ЗАСАГ, ХӨГЖЛИЙН ЯАМ

--- 000 ---

БОДЛОГЫН ТЭРГҮҮЛЭХ ЧИГЛЭЛ"-ИЙН ХҮРЭЭНД ХЭРЭГЖҮҮЛЭХ ҮНДСЭН ЗОРИЛТЫН ХЭРЭГЖИЛТ

№	Тэргүүлэх чиглэл	№	Зорилго	№	Зорилт	Зорилго, зорилтын биелэлт /2000 тэмдэгтэд багтаан бичнэ, ТЕЗ, хөтөлбөр, төсөл, арга хэмжээний үр дүнгийн биелэлттэй уялдуулж бичнэ./	Зорилтын хувь	Хариуцагч
1	Нэг.Экспортыг нэмэгдүүлнэ.	1	1.1.Нүүрсний экспортын биет хэмжээг 50 сая тоннд, зэсийн экспортын биет хэмжээг 1.5 сая тоннд, газрын тосны экспортын биет хэмжээг 6 сая баррельд хүргэж, уул уурхайн салбарын экспортыг нэмэгдүүлнэ.	1	1.1.1.Экспортын биет хэмжээг нэмэгдүүлэх авто зам, төмөр зам, төмөр замын холболтын төслүүдийг хэрэгжүүлж, тээврийн салбарын ачаа тээвэрлэх хүчин чадлыг нэмэгдүүлнэ.	Зам, тээврийн салбарын нийт ачаа тээвэр 2024 онд бүх төрлийн тээвэрээр нийт 126.9 сая тонн ачаа тээвэрлэсэн бөгөөд үүний дотор экспортын тээврийн хэмжээ 87.2 сая тонн болж. 2023 оны жилийн эцсийн дүнг давсан бөгөөд өмнөх оны мөн үеэс 22.2 хувиар өссөн нь мөн түүхэн дээд үзүүлэлт боллоо. 2024 онд автотээвэрээр 84.1, төмөр замаар 42.8 сая.тн ачаа тус тус тээвэрлэн түүхэн дээд амжилтыг шинэчлэн тогтоолоо. Авто замын салбарт 2024 онд нийт 559.5 км хатуу хучилттай авто зам, 173.9 урт метр гүүрийг шинээр ашиглалтад орууллаа. Үүнээс Олон улс, улсын чанартай авто замын сүлжээ 223.05 км хатуу хучилттай авто замаар нэмэгдэж, нийт урт 7750.1 км боллоо.	90	Зам, тээврийн яам
				80	2	1.1.2.Хилийн боомтуудын ачаа болон зорчигч нэвтрүүлэх, логистикийн үйлчилгээний хүчин чадлыг нэмэгдүүлэх төслүүдийг хэрэгжүүлнэ. Бичигт боомт АХБ-ны хөнгөлөлттэй зээлийн МОН/3810 төслийн хүрээнд: а/"Бичигт боомтын авто зам, гадна инженерийн шугам сүлжээний угсралтын ажил"-ын гэрээг "Хурдны зам" ХХК, "Нэг шугам" ХХК-ийн түншлэлтэй 2022 оны 12 дугаар сарын 01-нд байгуулсан. Ажлын гүйцэтгэлийн явц -25%. б/"Бичигт хилийн боомтын барилга байгууламжийн угсралтын ажил"-ын гэрээг "Хилийн цэргийн 0119 дүгээр анги" ТӨААТҮГ-тай 2023 оны 06 дугаар сарын 30-нд байгуулсан. Ажлын гүйцэтгэлийн явц-10%. Гэрээний ерөнхий нөхцөлийн 75.1, 75.2 (д), 75.4-т заалтуудыг үндэслэн захиалагч байгууллагын зүгээс гэрээ цуцлах болсныг мэдэгдсэн БСҮХ-ны 2024 оны 12 дугаар сарын 17-ны өдрийн 02/1337 тоот албан бичгийг ХХЕГ болон Хилийн цэргийн 0119-р анги ТӨААТҮГ-т хүргүүлсэн. Хавирга, Булган, боомт: Азийн хөгжлийн банкны төсөл хэрэгжих Хавирга, Цагааннуур, Булган боомтуудад боомтын хөгжлийн төлөвлөгөө, түүний удирдлагын стратеги, үйл ажиллагааны төлөвлөгөөг Азийн хөгжлийн банкны техникийн туслалцааны хүрээнд боловсруулан авах саналаа төсөл хэрэгжүүлэх нэгж (Best)-ийн зохицуулагчид тавьсан. МОН (55044-002) Хилийн Үр Ашгийг Нэмэгдүүлэх Тогтвортой Худалдаа (BEST) төслийг эхлүүлэх бэлтгэл ажлыг хангах хүрээнд Азийн хөгжлийн банкаас зохион байгуулсан хуралд 2024 оны 04 дүгээр сарын 18-аас 19-ний өдрүүдэд оролцож, АХБ-ны зээлийн хэлбэрүүд болон зээл олгоход тавигдах шаардлагууд, Парисын гэрээний шаардлагад нийцүүлэх дизайны төлөвлөлтийн өөрчлөлтүүд, төсөл хэрэгжүүлэх ерөнхий төлөвлөгөө, 2024 оны 05 дугаар сарын 06-аас 10-ны өдрүүдэд Булган, Хавирга, Цагааннуур боомтуудын дахин төлөвлөлтийг АХБ-ны байгаль орчны болон нийгмийн хамгааллын бодлогод нийцүүлэх шаардлага, төслийн явцын хяналт үнэлгээний тайлан, АХБ-ны худалдан авалт болон хөрөнгө зарцуулах үйл ажиллагаа, төслийн санхүүжилтийн төлөвлөгөө, 2024 оны 06 дугаар сарын 04-өөс 06-ны өдрүүдэд АХБ-ны оффист АХБ-ны худалдан авах ажиллагаа, байгаль орчин, нийгэм хамгааллын шаардлага, 2024 оны 06 дугаар сарын 09-өөс 12-ны өдрүүдэд АХБ-ны техник туслалцааны хүрээнд зохион байгуулсан FIDIC-ийн гэрээний сургалт сэдэвт 3 удаагийн сургалтад холбогдох төрийн байгууллагын төлөөллүүд хамрагдсан бөгөөд хамтран ажиллах санамж бичгийн төсөлд саналаа өгсөн. Азийн хөгжлийн банкны холбогдох албан тушаалтнуудтай Хавирга, Цагааннуур, Булган боомтуудад хийгдэх бүтээн байгуулалтын ажлыг эрчимжүүлэх чиглэлээр холбогдох төрийн байгууллагуудыг оролцуулан уулзалт зохион байгуулж, Хилийн боомтын захиргаа болон Азийн хөгжлийн банк хооронд Ховд аймгийн Булган сумын Булган боомтын байгаль орчны үнэлгээг Б зэрэглэлд оруулах асуудлаар хийсэн албан уулзалтыг 2024 оны 01 дүгээр сарын 29-31-ний өдрүүдэд Хилийн боомтын захиргааны хурлын танхимд зохион байгуулав. . Боомт хот тосгоны эдэлбэр газрын хэмжээг тогтооходоо тусгай хамгаалалтад хамрагдаж буй хэсгийг хамруулахгүй байхаар төслийг боловсруулсан бөгөөд Ховд аймгийн Булган боомтын суурьшлын бүсийг тусгай хамгаалалттай газар нутгаас гарган Булган сумын төвд байгуулахаар тогтоод байна. • БНХАУ-ын ШУӨЗО-ны Алтай аймгийн зүгээс Булган-Такашикэн боомтын шинэ гарцыг Хилийн 126, 127-р тэмдэгтээр нээхээр дэмжиж байгаага илэрхийлсэн. Монгол Улсын тухайд уг бүтээн байгуулалтыг төр хувийн хэвшлийн хамтын ажиллагааны түвшинд шийдвэрлэхээр төлөвлөн ажиллаж байна. Улсын төсвөөр хийх ажлын 2025 оны саналд Булган боомтын ачаа тээврийн терминалыг хилийн 126, 127-р тэмдэгтэд шилжүүлж буйтай холбогдуулан зураг төсөв хийлгэх төслийг Сангийн яамны "Төсвийн хөрөнгө оруулалтын удирдлагын цахим систем"-д бүртгүүлсэн. Мөн тус төслийн саналыг Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хуулиар Тэргүүн Шадар сайд бөгөөд Эдийн засаг, хөгжлийн сайдын багцад "Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний техник, эдийн засгийн үндэслэл, зураг төсөв" арга хэмжээнд тусгагдах зураг төсөв хийгдэх ажилд тусгасан. Хилийн Булган боомтын 126,127-р тэмдэгтээр хийх шинэ гарцын бүтээн байгуулалтын асуудлаар "МоЭнКо" ХХК-ийн захирал н.Оюунчимэг, хуулийн зөвлөх н.Түвшинзаяа нартай уулзаж, төр хувийн хэвшлийн хамтын ажиллагааны түвшинд шийдвэрлэхээр тохиролцсон. н.Оюунчимэг захирал зураг төсөв бэлэн болсон үед ярилцах боломжтой гэдгээ илэрхийлсэн. Хилийн Булган боомтын 126,127-р тэмдэгтийн шинэ гарцын бүтээн байгуулалтын ажлын зураг төсөв хийх зардлыг 2025 оны улсын төсөвт суулгаж, шийдвэрлүүлэхээр санал хүргүүлсэн. Энэ ажилд аймгийн Засаг дарга н.Амарсанаа онцгойлон анхаарахаа илэрхийлсэн. Хятадын тал уг гарцын зураг төсвөө шинэчлэн хийсэн батлагдах шатандаа явж байна. Нүүрс тээврийн тусгай гарцын өргөтгөл нь 1 гарц, 1 орцыг 2 гарц, 1 орц болгож ачаа эргэлтийг нэмэгдүүлэх зорилготой. 1-р хувилбарын ажлаа 2023 оны 11-р сарын 15-нд дууссан. /Энэ нь пүүг зөөж шинэ байрлалд шилжүүлж, цементэн дүүргэлт хийсэн. Нүүрсний замын 2-ын хаалтын хаалгыг 2 эгнээ ачаатай машин орох боломжтой болгож өргөтгөх ажил хийсэн/. 2-р хувилбарын ажлыг 2024 оны 03-р сард эхлэх байсан боловч цаг агаарын нөхцөл байдлаас шалтгаалж хойшилсон ба ажлаа эхлүүлэх талаар шаардлага тавьж ажилласан. Энэ асуудлаар Улаанбаатар хотод томилолтоор ажиллаж, "МоЭнКо" ХХК-ийн захирал н.Оюунчимэг, хуулийн зөвлөх н.Мөнгөнзаяа нартай тус компанийн төв байранд уулзалт хийж, санал солилцсон. Хэлэлцсэн асуудлаар буюу компанийн нүүрс экспортын төлөвлөлт, өргөтгөл шинэчлэлийн ажлын талаар болон шинээр хийгдэх нүүрс баяжуулах үйлдвэр, гаалийн хяналтын талбай зэрэг бүтээн	70	Боомтын сэргэлтийн Үндэсний хороо, Сангийн яам, Зам, тээврийн яам

2	Гадаад худалдааг хөнгөвчлөх, экспортыг төрөлжүүлэх, хөдөө аж ахуйн гаралтай бүтээгдэхүүний боловсруулалтын түвшнийг ахиулах замаар уул уурхайн бус экспортыг нэмэгдүүлнэ.		1.2.1.Уул уурхайн бус бүтээгдэхүүнд зориулсан экспортын санхүүжилт, даатгал, төлбөрийн баталгаа, зээлийн батлан даалт зэргээр экспортыг дэмжих санхүүжилтийн тогтолцоог бий болгоно.	<p>С.Я:Уул уурхайн бус бүтээгдэхүүнд зориулсан экспортын санхүүжилт, даатгал, төлбөрийн баталгаа, зээлийн батлан даалт зэргээр экспортыг дэмжих санхүүжилт, даатгал, төлбөрийн баталгаа, зээлийн батлан даалт зэргээр экспортыг дэмжих санхүүжилтийн тогтолцоог бий болгоно.</p> <p>С.Я:Уул уурхайн бус бүтээгдэхүүнд зориулсан экспортын санхүүжилт, даатгал, төлбөрийн баталгаа, зээлийн батлан даалт зэргээр экспортыг дэмжих санхүүжилт, даатгал, төлбөрийн баталгаа, зээлийн батлан даалт зэргээр экспортыг дэмжих санхүүжилтийн тогтолцоог бий болгоно.</p>	3		70	Сангийн яам, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам, Санхүүгийн зохицуулах хороо
		76	1.2.2.Экспортын баримжаатай хөдөө аж ахуйн бүтээгдэхүүний боловсруулалтын түвшнийг ахиулах үйлдвэрлэл, технологийн паркуудын дэд бүтцийн хөрөнгө оруулалтыг хийнэ.	<p>ХХАХҮЯ: Ховд аймагт хэрэгжиж буй "Шинэ Ховд" үйлдвэр технологийн паркийн төслийн хөрөнгө оруулалт 2022 оноос хэрэгжиж эхэлсэн бөгөөд 2025 онд гэрээт ажил бүрэн дуусахаар төлөвлөж, магадлалын дүгнэлтээр төсөвт өртөг нэмэгдэж 36,018.1 сая төгрөгөөр батлагдсан байна. Тус төслийг 5-н багц арга хэмжээнд хувааж тендер шалгаруулалтыг явуулснаас Оффрөүд таван богд ХХК, Воком констракшн ХХК, Эм Ай Эс Эс ХХК, Монкабель ХХК, Жаргалантлуу ХХК тус тус шалгарч 36,018.1 сая төгрөгийн санхүүжилтээ гүйцэтгэлээр 2023 он дуустал хугацаанд 9,571.5 сая төгрөгийн санхүүжилт авч, 2024 онд 11,297.4 сая төгрөгийн санхүүжилт олгохоор гүйцэтгэлийг хянан баталгаажуулаад байна. 2025 онд 18,184.0 сая төгрөг Улсын төсөвт батлагдсан.Нийт ажлын гүйцэтгэл 2024 оны жилийн эцсийн байдлаар 57,94 хувьтай байна. 2.Дархан арьс ширний цогцолборын дэд бүтцийн бүтээн байгуулалтын хүрээнд Эрдэнэт үйлдвэрээс санхүүжих 50 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалтаас өссөн дүнгээр Бүтээн байгуулалтын үеийн түр цахилгаан хангамжийн зураг төсөв - "Энержи бөх бат" ХХК-д 151 сая төгрөг, Үхрийн шир боловсруулах үйлдвэрийн барилгын зураг - "Ди ди эй жи" ХХК -д 191,04 сая төг , Ямааны арьс боловсруулах үйлдвэрийн зураг - "Эм эс эл" ХХК -д 264,6 сая төг , Хонины арьс боловсруулах үйлдвэрийг зураг- "Классик хаус" ХХК-д 257,6 сая төг, Түүхий эд, агуулахын барилгын зураг -"Алтан хөхий очир" ХХК -д 87,2 сая төг, Химийн материалын агуулахын зураг- "Ди ди эй жи" ХХК -д 66,16 сая төг, Дэд бүтцийн ажлын зураг төсвийн зардал- "Аркасис" ХХК-д 713,8 сая төгрөг тус тус санхүүжилт хийгдээд байна. Үүнээс 2024 онд 1,3 тэрбум төгрөгийн санхүүжилт олгогдсон. Мөн "Дархан арьс ширний цогцолбор төслийг эрчимжүүлэх арга хэмжээний тухай" МУЗГ-ын тогтоолын төслийг 2024 оны 04 дүгээр сарын 24-ний өдрийн хуралдаанаар хэлэлцээд Засгийн газрын гишүүдийн гаргасан саналын дагуу хойшуулав.Өнөөдрийн байдлаар зураг төсөл төсөл боловсруулах ажил дуусаж, магадлалд хянагдаж байна.С.Я:2024 онд төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний жагсаалтад "Шинэ Ховд" үйлдвэр технологийн паркийн бүтээн байгуулалт, хөрөнгө оруулалт /Ховд, Жаргалант сум/" төслийн гүйцэтгэлд 7,6 тэрбум төгрөгийн санхүүжилт олгосон. Мөн "Хөдөө аж ахуй, үйлдвэрлэлийн кластер байгуулах /Баянхонгор/" төсөлд 1,7 тэрбум төгрөг, "Хөдөө аж ахуйн Кластер төслийн газар тариалан, малын тэжээлийн дэд төсөл /Баянхонгор/" төсөлд 5,0 тэрбум төгрөгийг тус тус олгосон. 2024 оны төлөвлөгөөнд "Үйлдвэрлэл, технологийн паркийн дэд бүтэц /Сүхбаатар/" төсөл, арга хэмжээнд 609,3 сая төгрөг, "Хөдөө аж ахуйн үйлдвэржилтийн агропарк /Сэлэнгэ/" төсөлд 3,0 тэрбум төгрөг батлагдсан боловч 12-р сарын 3-ны өдрийн байдлаар санхүүжилт аваагүй байна. Засгийн газрын 2022 оны 9-р тогтоолд "Дархан арьс ширний цогцолбор"-ын бүтээн байгуулалтад шаардлагатай Монголын талаас гаргах 50.0 тэрбум төгрөгийг "Эрдэнэт үйлдвэр" ТӨҮГ-аас санхүүжүүлэхээр заасан. 548.1 сая төгрөгийг Сангийн яамны төрийн банкин дахь дансанд байршуулахыг хүссэн 09/4099 тоот албан бичгийг "Эрдэнэт үйлдвэр" ТӨҮГ руу явуулсан.</p>	4		70	Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам, Сангийн яам
			1.2.3.Олон улсын худалдаанд хориг саад үүсгэдэг мал, амьтны гоц халдварт өвчний тархалтыг бүрэн хяналтад авч, өвчний тархалтыг хязгаарлах зорилготой аж ахуйн үйлдвэрлэл, технологийн паркуудын дэд бүтцийн хөрөнгө оруулалтыг хийнэ.	<p>2024 оны эхний хагас жилийн байдлаар шүлхий, үхрийн арьс товруулах өвчний голомт бүртгэгдээгүй тайван байна. Бог малын мялзан: 2024 он гарсаар 2 аймгийн 2 суманд 2 голомт бүртгэгдэж, 2024 оны 01 дүгээр сарын 06-ны өдрөөс 2024 оны 03 дугаар сарын 12-ны өдрийн хооронд хорио цээр, хязгаарлалтын шаардлага бүрэн цуцалсан. Өнөөдрийн байдлаар тус өвчний голомтгүй, тайван байна. Хонины цэцэг: Улсын хэмжээнд 2024 оны 1 дүгээр сарын 01-ний өдрөөс хойш 12 аймгийн 65 суманд 85 голомт бүртгэгдэж, өнөөдрийн байдлаар 6 аймгийн 19 суманд 22 голомтод хорио цээрийн болон хязгаарлалтын дэглэм хэрэгжиж байна. Бог малын мялзан өвчинтэй тэмцэх арга хэмжээг сайжруулах зорилгоор БММӨ-ний хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж Дэлхийн БММӨ-ний нарийн бичгийн дарга нарт хүргүүлсэн. Шүлхий өвчинтэй тэмцэх албан ёсны хөтөлбөрийг боловсруулах, ДМАЭМБ-д илгээж түлээн зөвшөөрүүлэх чиг үүрэг бүхий ажлын хэсэг байгуулагдан 08 дугаар сарын 30-ны өдрийн дотор хөтөлбөрийг илгээхээр ажиллаж байна.</p>	5		70	Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам
			1.2.4.Гадаад худалдааны процесс, хилийн хяналтын байгууллагуудын үйл ажиллагааг хялбаршуулан, шаарддаг гэрчилгээ, зөвшөөрөл, бичиг баримтын тоог боломжит хамгийн бага түвшинд хүртэл бууруулж, "Гадаад худалдааны цахим нэг цонхны үйлчилгээ"-г нэвтрүүлж, гадаад худалдаанд зарцуулах хугацааг 72 цагт хүргэнэ.	<p>ЭЗХЯ:Худалдааг хөнгөвчлөх бодлогын хүрээнд гадаад худалдааны үйл ажиллагааг бүрэн цахимжуулж, оролцогч байгууллагууд болон гадаад худалдаа эрхлэгчдэд тулгарч буй хүндрэлүүдийг бууруулах хүрээнд Гадаад худалдааны цахим нэг цонх мэдээллийн систем нэвтрүүлэх ажлыг албан ёсоор эхлүүлээд байна. Тус мэдээллийн системийн "Ажлын даалгавар"-ыг шинэчилсэн бөгөөд АХБ-тай хамтран 3 сарын 21-23-ны өдрүүдэд тус системийн талаарх техникийн сургалт, хэлэлцүүлгийг холбогдох байгууллагуудын төлөөллийг хамруулан зохион байгуулсан. Мөн системийг нэвтрүүлэх, ашиглахтай холбогдуулан хууль эрх зүйн орчны судалгаа, дүн шинжилгээг хийсэн бөгөөд ЦХИХХЯЯмаанаас ГХЦНЦ системийн дүгнэлт, зөвлөмж хүлээн авч, ажлын даалгаврыг баталсан. Тус системийг хөгжүүлэх, нэвтрүүлэх олон улсын гүйцэтгэгч сонгон шалгаруулахаар Төрийн худалдан авах ажиллагааны газар тендерийн үнэлгээний хороо байгуулж, тендерийн баримт бичгүүдийг эцэслэн боловсруулсан С.Я: Эдийн засгийн гадаад хамтын ажиллагаа, гадаад дотоод худалдааны бодлого, зохицуулалтын асуудал нь Засгийн газрын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 5 дахь хэсгийн 2-д заасны дагуу Шадар сайд бөгөөд Эдийн засаг, хөгжлийн сайдын эрхлэх асуудалд хамаарах тул тус арга хэмжээний хэрэгжилтийг Эдийн засаг, хөгжлийн яамнаас авах нь зүйтэй байна.-Хамааралгүй ХЗДХЯ:Монгол Улсын хилийн тухай хуулийн 1.16 дахь заалт "хилийн хяналтын байгууллага" гэж улсын хил нэвтрэх зорчигч, тээврийн хэрэгсэл, бараа, мал, амьтан, ургамал, тэдгээрийн гаралтай түүхий эд, бүтээгдэхүүнд хяналт шалгалт явуулах, бүртгэх эрх бүхий улсын хил хамгаалах, гааль, мэргэжлийн хяналт, гадаадын иргэн, харьяатын байгууллагыг"-д, 2021 онд өөрчлөлт оруулж, хилийн боомтод ажиллах хилийн хяналтын байгууллагын тоог багасган, мэргэжлийн хяналтын албаны чиг үүргийг Гаалийн байгууллагын чиг үүрэгт хамааруулж, хяналт шалгалтын давхцалыг багасгасан. Олон улсын иргэний нисэхийн байгууллага (ИКАО)-ын агаарын тээврийг хялбаршуулах талаар гаргасан дүрэм журмын дагуу Засгийн газрын 2021 оны 137 дугаар тогтоолоор баталсан "Агаарын тээврийг хялбаршуулах журам"-ын дагуу олон улсын агаарын боомтод хяналт шалгалтыг хялбаршуулан иргэдэд үйлчилж байна. "Улсын хилээр нэвтэрч буй зорчигч, тээврийн хэрэгслийн бүртгэл, мэдээллийн нэгдсэн сан"-гийн хөгжүүлэлт, шинэчлэлийг "Гэрэгэ системс" ХХК-аар гүйцэтгүүлэн 2024 оноос хилийн боомтуудад нэвтрүүлсэн. Тус мэдээллийн санг Гаалийн байгууллагын "CAIS" автоматжуулсан системтэй мэдээлэл солилцох хөгжүүлэлтийг хийн, улсын хилээр нэвтрэх тээврийн хэрэгслийн мэдээллийг солилцох ажлыг зохион байгуулж байна.</p>	6		100	Эдийн засаг, хөгжлийн яам, Сангийн яам, Хууль зүй, дотоод хэргийн яам
			1.2.5.Ноолуур, мах, арьс, шир, самар, эмийн ургамал, хүнсний бүтээгдэхүүний экспортыг нэмэгдүүлэх, экспортын орцыг импортны тарифаас чөлөөлөх, боловсруулалтын түвшнийг ахиулж, экспортыг төрөлжүүлнэ.	<p>ХХАХҮЯ:БНХАУ-д мах, махан бүтээгдэхүүн экспортлох 20, самар экспортлох 7 аж ахуйн нэгжийн ирүүлсэн материалыг хянан баталгаажуулан, шалгалтыг зохион байгуулснаар тус улсын ГЕГ-ын цахим системд мах, махан бүтээгдэхүүн экспортлох 7 , самар экспортлох 5, загас экспортлох 1 буюу нийт 14 аж ахуйн нэгжийг шинээр бүртгүүлсэн.https://ciferquery.singlewindow.cn/. Малын гаралтай түүхий эдийг боловсруулах үйлдвэрлэлийг дэмжих "Цагаан алт" хөдөлгөөнийг өрнүүлж УИХ-ын 63 дугаар тогтоолыг батлуулж энэ хүрээнд олгогдох зээлийн санхүүжилтийн гэрээ албажсан. https://legalinfo.mn/mn/detail?lawId=17140837405211. Хөнгөн, хүнсний үйлдвэрлэлийн 19 салбарын 428 нэр төрлийн тоног төхөөрөмжийг импортны барааны гаалийн албан татвараас 100% хөнгөлөх ЗГ-ын 2023 оны 107 дугаар тогтоолын хүрээнд 2024 онд Монгол Улсад 122 аж ахуйн нэгжийн импортлосон тоног төхөөрөмжид 6.8 тэрбум төгрөгийн гаалийн албан татварын хөнгөлөлтийг үзүүлсэн 2024 оны 11 сарын байдлаар 20 гаруй нэрийн хөдөө аж ахуйн гаралтай бүтээгдэхүүнийг экспортлосон байна. С.Я:Малчдын татварын орчныг энгийн, ойлгомжтой болгох, хялбаршуулах, татварын эрсдэлийг бууруулах, дотоодын боловсруулах үйлдвэрүүдэд тулгараад буй хүндрэлтэй асуудлыг шийдвэрлэх, малын гаралтай боловсруулсан бүтээгдэхүүний экспортыг нэмэгдүүлэх зорилгоор Улсын Их Хурлаас 2023 оны 11 сарын 10-ны өдөр баталсан Монгол Улсын 2024 оны төсвийн тухай хуулийг дагалдуулан Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хууль нэмэлт оруулсан. Тус нэмэлтээр малчин, мал бүхий этгээдийн борлуулсан таван хошуу мал, анхан шатны боловсруулалтад ороогүй мах, сүү, арьс шир, хонь болон тэмээний ноос, ноодны сарвагийн хөвчийг НӨАТ-ээс чөлөөлөн</p>	7		70	Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам, Сангийн яам

2	Хоёр.Хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлнэ.	3	2.1.Хөрөнгө оруулагчдад дэмжлэг, үйлчилгээ үзүүлэх, хөрөнгө оруулалт татах, хамгаалах цогц механизмыг бүрдүүлэх замаар хөрөнгө оруулалт хийх, бизнесийн үйл ажиллагаа эрхлэх таатай орчныг бүрдүүлнэ.	8	2.1.1.Хөрөнгө оруулалт хийх, бизнесийн үйл ажиллагаа эрхлэхэд төрөөс зөвшөөрөл авахад дэмжлэг тусалцаа үзүүлэх, мэдээ мэдээллээр хангах, зөвлөгөө өгөх цогц үйлчилгээг үзүүлж, хөрөнгө оруулагчийн хууль ёсны эрх, ашиг сонирхлыг хамгаалах, гаргасан гомдлыг цахимаар хүлээн авч шийдвэрлэнэ. Мөн төрөөс бизнесийн үйл ажиллагаанд хийгддэг давхардсан хяналт шалгалтыг бууруулна.	ЭЗХЯ:Монгол Улсын Засгийн газрын 2023 оны 37 дугаар тогтоолоор "Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг - Хөрөнгө оруулалт, худалдааны газар"-ыг байгуулсан бөгөөд Шадар сайд бөгөөд Эдийн засаг, хөгжлийн сайдын тушаалаар баталсан Хөрөнгө оруулалт, худалдааны газрын үйл ажиллагааны стратеги, зохион байгуулалтын бүтцийн өөрчлөлтийн хөтөлбөрийг дагуу тус газраас хөрөнгө оруулагчдад дэмжлэг, тусалцаа үзүүлэх, мэдээ мэдээллээр хангах, зөвлөгөө өгөх чиг үүргийг хэрэгжүүлэн ажиллаж байна. Мөн ХОХГ-ын дэргэдэх нэг цэгийн үйлчилгээний төвөөр дамжуулан улсын бүртгэл, татвар, нийгмийн даатгал, гадаадын иргэн харьяатын асуудал эрхэлсэн 5 төрийн захиргааны байгууллагаас холбогдох мэдээлэл, зөвлөгөө өгөх үйлчилгээг хөрөнгө оруулагчдад үзүүлэн ажиллаж байна. Монгол Улсын Их Хурлын 2024 оны 13 дугаар тогтоолоор "Төрийн захиргааны байгууллагын тогтолцоо, бүтцийн ерөнхий бүдүүвч" шинэчлэн батлагдсан бөгөөд Хөрөнгө оруулалт, худалдааны газар Гадаад худалдаа, хөрөнгө оруулалт хариуцсан Шадар сайдын эрхлэх асуудалд шилжсэн. -Гадаадын хөрөнгө оруулалттай аж ахуйн нэгжүүдээс ирүүлсэн гомдлыг хүлээн авч, холбогдох төрийн байгууллагуудаас тодруулга мэдээлэл авч, шийдвэрлүүлэхээр ажиллаж байна. - Хөрөнгө оруулалтын тухай хуулийн шинэчилсэн найруулгад "Төрийн хяналт шалгалтыг давхардалгүй төлөвлөн, хэрэгжүүлэх, төлөвлөгөөт хяналт шалгалтын тоо жилд хоёроос ихгүй байна." гэж тусгасан. ХЗДХЯ:Монгол Улсын Шадар сайд Т.Доржжандаас ирүүлсэн Хөрөнгө оруулалтын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийн үзэл баримтлалыг баталж 2024 оны 12 дугаар сарын 26-ны өдрийн 1/2610 албан бичгээр хүргүүлсэн. Мөн Арбитрын тухай хуулийн хэрэгжилтийн үр дагаврын судалгааг хийсэн бөгөөд Хууль зүй, дотоод хэргийн яам, Монгол Улсын Их Сургуулийн Хууль зүйн сургуультай хамтран арбитраар маргааныг шийдвэрлэх үйл ажиллагаанд тулгамдаж буй асуудал, цаашдын чиг хандлагыг тодорхойлох хүрээнд "Арбитрын тухай хуулийн хэрэгжилтийн үр дагаварт хийсэн судалгаа"-ны тайлан, хэлэлцүүлгийг 2024 оны 11 дүгээр сарын 01-ний өдөр зохион байгуулсан бол Арилжааны хуулийн төслийн үзэл баримтлалын төсөл, хуулийн төсөл болон түүнийг дагаж гарах хуулийн төслүүд, тэдгээрийн товч, дэлгэрэнгүй танилцуулгыг боловсруулж, хуулийн төслийн үр нөлөөний үнэлгээ, зардлын тооцоо хийсэн. Монголын үндэсний худалдаа, аж үйлдвэрийн танхимтай хамтран 2024 оны 01 дүгээр сарын 25-ны өдөр "Арилжааны хуулийн төслийн үзэл баримтлал, зарим асуудал" сэдэвт хэлэлцүүлгийг, мөн МХХ-тай хамтран 2024 оны 02 дугаар сарын 22-ны өдөр "Арилжааны хуулийн төсөл" сэдэвт хэлэлцүүлгийг тус тус зохион байгуулсан. Худалдаа, аж үйлдвэрийн танхимын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон уг хуулийн төсөлтэй холбогдуулан боловсруулсан бусад хуулийн төслийг 2024 оны 04 дүгээр сарын 17-ны өдөр Монгол Улсын Их Хурал өргөн мэдүүлсэн. Мөн хуулийн төслийг 2024 оны 05 дугаар сарын 17-ны өдрийн УИХ-ын чуулганы нэгдсэн хуралдаанаар хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжсэн.	100	Эдийн засаг, хөгжлийн яам, Засгийн газрын Хэрэг эрхлэх газар, Хууль зүй, дотоод хэргийн яам
				9	2.1.2.Банк, санхүүгийн салбарын өрсөлдөөнийг нэмэгдүүлэх замаар санхүүгийн үйлчилгээний зардлыг бууруулж, хөрөнгө оруулалтын эх үүсвэрийг нэмэгдүүлнэ.	МБ: Үндэсний статистикийн хорооноос 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаарх Дотоодын нийт бүтээгдэхүүн (ДНБ)-ий гүйцэтгэлийг 2025 оны 2 дугаар сарын 15-ны өдрөөс зарлах тул 2024 оны 11 дүгээр сарын хөрөнгийн зах зээлийн үнэлгээний дүнг 2023 оны 4 дүгээр улирлаас 2024 оны 3 дугаар улирал хүртэлх ДНБ-ний нэрлэсэн дүнд эзлэх хувиар хүрсэн түвшинг тооцов. Хүрсэн түвшин /2024.III/ 16%	90	Монголбанк, Санхүүгийн зохицуулах хороо
				10	2.1.3.Эдийн засгийн түншлэлийн хэлэлцээр, Чөлөөт Хөрөнгө оруулалтыг хөхиүлэн дэмжих, харилцан хамгаалах тухай хэлэлцээрүүдийг байгуулж, аж ахуйн нэгж, байгууллагуудад гадаад худалдаа, экспорт хийх таатай нөхцөл, боломжийг бүрдүүлнэ.	ГХЯ:Худалдааг хөнгөвчлөх, Засгийн газрын худалдан авалт, Худалдаан дахь техникийн саад тотгор, Эрүүл ахуй, ургамлын эрүүл ахуйн арга хэмжээ, Эдийн засгийн хамтын ажиллагаа, Оюуны өмч, Өрсөлдөөн, Байгаль орчин, Цахим худалдаа, Хууль эрх зүйн болон институцын асуудал гэсэн үндсэн 14 бүлгээс бүрдэнэ. Хэлэлцээрийн үр дүнд хоёр улс хоорондын худалдаан дахь тарифын болон тарифын бус саад бэрхшээл буурч, худалдааг хөнгөвчлөх, бизнесийн таатай орчныг бүрдүүлэх, хөрөнгө оруулалт татах, бүхий л салбарт хамтын ажиллагааг хөгжүүлэх, өргөжүүлэх, экспортлогчдын зах зээл тэлж, өрсөлдөх чадвар, бараа, үйлчилгээний чанар, аюулгүй байдал сайжрах, дотоодод нийлүүлэх барааны үнэ, хангамж тогтворжих бөгөөд тус хэлэлцээр нь хоёр улсын "Стратегийн түншлэл"-ийн харилцааг улам бэхжүүлж,түүгээр тохиролцсон бүхий л салбарын хамтын ажиллагааг өргөжүүлэх ач холбогдолтой. Мөн Монголын хөдөө аж ахуйн гаралтай бүтээгдэхүүнийг татваргүйгээр ОХУ-ын зах зээлд гаргах зорилгоор ЕЭАХХ-той Худалдааны түр хэлэлцээрийг байгуулахаар хэлэлцээрийн төслийг эцэслэн тохиролцсон. Тус хэлэлцээрийн үр дүнд монголын экспортлох боломж бүхий харьцангуй давуу талтай хөдөө аж ахуйн гаралтай голлох бараанууд Улс хоорондын Эдийн засгийн түншлэлийн хэлэлцээрийн албан ёсны яриа хэлэлцээр 2023 оноос эхэлсэн бөгөөд 2024 оны жилийн эцсийн байдлаар талууд нийт 4 удаагийн албан ёсны яриа хэлэлцээг дараах байдлаар зохион байгуулаад байна. Үүнд: 1. Эхний шатны хэлэлцээг 2023 оны 12 дугаар сарын 18-20-ны өдрүүдэд БНСУ-ын Сөүл хотноо, 2. Хоёр дахь шатны хэлэлцээг 2024 оны 5 дугаар сарын 21-23-ны өдрүүдэд Улаанбаатар хотноо, 3. Гурав дахь шатны хэлэлцээг 2024 оны 9 дүгээр сарын 10-13-ны өдрүүдэд Улаанбаатар хотноо 4. Дөрөв дэх шатны хэлэлцээг 2024 оны 11 дүгээр сарын 25-29-ний өдрүүдэд БНСУ-ын Сөүл хотноо. Хэлэлцээрийн төсөл нь Бараа, Үйлчилгээ, Хөрөнгө оруулалт, Гарал үүслийн дүрэм, Гаалийн үйл ажиллагаа ба Худалдааг хөнгөвчлөх, Засгийн газрын худалдан авалт, Худалдаан дахь техникийн саад тотгор, Эрүүл ахуй, ургамлын эрүүл ахуйн арга хэмжээ, Эдийн засгийн хамтын ажиллагаа, Оюуны өмч, Өрсөлдөөн, Байгаль орчин, Цахим худалдаа, Хууль эрх зүйн болон институцын асуудал гэсэн үндсэн 14 бүлгээс бүрдэнэ. Хэлэлцээрийн үр дүнд хоёр улс хоорондын худалдаан дахь тарифын болон тарифын бус саад бэрхшээл буурч, худалдааг хөнгөвчлөх, бизнесийн таатай орчныг бүрдүүлэх, хөрөнгө оруулалт татах, бүхий л салбарт хамтын ажиллагааг хөгжүүлэх, экспортлогчдын зах зээл тэлж, өрсөлдөх чадвар, бараа, үйлчилгээний чанар, аюулгүй байдал сайжрах, дотоодод нийлүүлэх барааны үнэ, хангамж тогтворжих бөгөөд тус хэлэлцээр нь хоёр улсын "Стратегийн түншлэл"-ийн харилцааг улам бэхжүүлж,түүгээр тохиролцсон бүхий л салбарын хамтын ажиллагааг өргөжүүлэх ач холбогдолтой. Мөн Монголын хөдөө аж ахуйн гаралтай бүтээгдэхүүнийг татваргүйгээр ОХУ-ын зах зээлд гаргах зорилгоор ЕЭАХХ-той Худалдааны түр хэлэлцээр байгуулахаар хэлэлцээрийн төслийг эцэслэн тохиролцсон. Тус хэлэлцээрийн үр дүнд монголын экспортлох боломж бүхий харьцангуй давуу талтай хөдөө аж ахуйн гаралтай голлох бараанууд бүгд татваргүйгээр экспортлогдох боломжтой бөгөөд махны квотын хязгаарлалтгүйгээр экспортлох юм.	90	Гадаад харилцааны яам, Эдийн засгийн хөгжлийн яам
				70	2.2.1. Геологи, хайгуулыг ажлыг эрчимжүүлэн, ашигт малтмалын хайгуулын тусгай зөвшөөрөл олгохыг нэмэгдүүлж, улмаар ашигт малтмалын батлагдсан нөөцийг өсгөнө. Мөн зэсийн ордын ашиглалтыг нэмэгдүүлэх замаар хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлнэ.	Холбогдох хууль, журамд заасны дагуу www.tender.gov.mn платформ-оор сонгон шалгаруулалтыг зарлан тусгай зөвшөөрлийг олгож байгаа бөгөөд 5 дугаар сард цахимаар сонгон шалгаруулалт зарлагдаагүй. Гүйцэтгэл: Ашигт малтмалын хайгуулын тусгай зөвшөөрлийг сонгон шалгаруулалтаар олгох ажлын хүрээнд 2024 оны 05 дугаар сарын байдлаар 69.412.89 мянган га талбайг хамарсан 71 талбайд хайгуулын малтмалын тусгай зөвшөөрөл олгох сонгон шалгаруулалтыг 3 удаа зарлан үнэлгээ хийж, 42 хайгуулын тусгай зөвшөөрлийг шинээр олгосон. Улсын төсөвт 8.7 тэрбум төгрөг төвлөрүүлэхээр төлөвлөгөөнд тусгаснаас 34.8 тэрбум төгрөг төвлөрүүлээд байна. Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайдын 2023.12.01-ний өдрийн А/352 дугаар тушаалын дагуу "Ашигт малтмалын хайгуулын тусгай зөвшөөрөл олгох сонгон шалгаруулалтын комисс"-д ажиллаж СШ-64-65, 66 кодтой сонгон шалгаруулалтаар зарласан 50 талбайд ирүүлсэн 174 оролцогчдын материалд үнэлгээ хийсэн. Ашигт малтмалын тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.5.1, 17.7-д заасны дагуу сонгон шалгаруулалтаар ашигт малтмалын хайгуулын тусгай зөвшөөрөл олгох боломжтой 140 талбайн мэдээллийг Ашигт малтмал, газрын тосны газарт 2024 оны 02 дугаар сарын 27-ны өдрийн 03/465, 04 дугаар сарын 15-ны өдрийн 03/846, 05 дугаар сарын 08-ны өдрийн 02/1042 тоот албан бичгээр тус тус хүргүүлсэн ба нийт 140 сонгон шалгаруулалтын талбайг хүргүүлсэн. Албан бичгээр цахим системд үнэлгээний хорооны гишүүд үнэлгээ хийх ажлыг ил тод болгох, оролцогч нарт мэдээллийг багцлан оруулах, төрийн бусад байгууллагаас мэдээлэл татах зэрэг асуудлыг хялбаршуулахаар хөгжүүлэлт хийгдэж байна.	70	Аж үйлдвэр, эрдэс баялгийн яам
				90	2.3.Стратегийн ач холбогдол бүхий ашигт малтмалын ордуудын нөөцийг нарийвчлан тогтоож, эдийн засгийн эргэлтэд оруулах замаар Үндэсний баялгийн сангийн тогтолцоог бий болгоно.	АҮЭБЯ:Өмнөговь аймгийн Цогтцэций сумын нутагт орших Тавантолгой чулуун нүүрсний бүлэг ордын Цанхи, Бортээг болон Оорцогийн хэсэгт 2017-2022 онд гүйцэтгэсэн хайгуулын ажлын үр дүнгийн нөөцийн шинэчилсэн тайланг ЭБМЗ-өөр хэлэлцүүлж, ордын нөөцийг 2024 оны 01 дүгээр сарын 01-ний өдрийн байдлаар хүлээн авч ЭБМЗ-ийн 2024 оны 03 дугаар сарын 27-ны өдрийн СТР-2024-01 дугаар дүгнэлт гарсан.ЭЗХЯ:Монгол Улсын Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын даргын 2023 оны 55 дугаар тушаалаар "Үндэсний баялгийн сангийн тухай хуулийн төслийг боловсруулж, Улсын Их Хуралд өргөн мэдүүлэх ажлыг хариуцан зохион байгуулах чиг үүрэг бүхий "Эрдэнэс Монгол" ХХК-ийн гүйцэтгэх захирлаар ахлуулсан дэд ажлын хэсэг байгуулагдсан. Эдийн засаг, хөгжлийн яам нь тандан судалгаанд Норвег, Самрук Казына, Сингапурын сангуудын үйл ажиллагаанд хийсэн шинжилгээ, мэдээллээр хангаж, мөн Үндэсний баялгийн сангийн хуулийн төслийг Засгийн газар, Улсын Их Хурлын даргад танилцуулах материалыг боловсруулж ажилласан. Үндэсний баялгийн сангийн тухай хууль 2024 оны 04 дүгээр сарын 19-ны өдөр батлагдсан. Мөн Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын даргын 2024 оны хэрг/1757 дугаар албан бичгээр ирүүлсэн "Үндэсний баялгийн сангийн тухай хуулийг хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай" Засгийн газрын тогтоолын төсөлд тусгасан "Тодорхой ордыг стратегийн ач холбогдол бүхий ашигт малтмалын ордод хамааруулах тухай" Улсын Их Хурлын 2007 оны 02 дугаар сарын 06-ны өдрийн 27 дугаар тогтоолын 3 дахь заалтын хэрэгжилтийг хангах хүрээнд стратегийн ач холбогдол бүхий ашигт малтмалын ордын жагсаалтад өөрчлөлт оруулах саналыг дэмжин ажиллалаа. ХЗДХЯ:Засгийн газрын Хэрэг эрхлэх газраас ирүүлсэн "Стратегийн ач холбогдол бүхий ашигт малтмалын ордын төрийн эзэмшлийн хувь, хэмжээг оруулах тухай" Улсын Их Хурлын тогтоолын төсөлд 2024 оны 12 дугаар сарын 24-ны өдрийн 1/2556 тоот албан бичгээр, Үндэсний баялгийн сангийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөлд 2024 оны 12 дугаар сарын 24-ны өдрийн 1/2558 тоот албан бичгээр Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлэх зөвшөөрөл олгосон.Улсын Их хурлын 2024 оны 08 дугаар сарын 30-ны өдрийн чуулганаар Үндэсний баялгийн сангийн 2024 оны төсвийн хууль, 2024 оны 11 дүгээр сарын 08-ны өдрийн УИХ-ын чуулганаар Үндэсний баялгийн сангийн 2025 оны төсвийн хууль тус тус батлагдсан.	90	Аж үйлдвэр, эрдэс баялгийн яам, Эдийн засаг, хөгжлийн яам, Хууль зүй, дотоод хэргийн яам, Засгийн газрын Хэрэг эрхлэх газар
				70	2.4.Зэсийн баяжмал боловсруулах үйлдвэр, нүүрс баяжуулах үйлдвэр, гангийн үйлдвэр болон ураны олборлолт, хүдрийн баяжмал боловсруулах үйлдвэрүүдийг хувийн хэвшлийн хөрөнгө оруулалтаар байгуулж, боловсруулах үйлдвэрийг нэмэгдүүлнэ.	Эрдэнэт үйлдвэр" ТӨҮГ-ын түшиглэн байгуулах "Уул уурхай-металлурги-химийн үйлдвэрийн цогцолбор" үйлдвэрлэл, технологийн паркийн хүрээнд баригдах "Зэсийн баяжмал хайлуулах, боловсруулах үйлдвэрийн ТЭЗҮ"-ийг Эрдэс баялгийн мэргэжлийн зөвлөлийн 2022.06.22-ны өдрийн өргөтгөсөн хуралдаанаар хэлэлцэж хүлээн авсан бөгөөд ЗБХБҮ-ээс ялгарах хүхрийн давхар исэл агуулсан хийг цэвэршүүлэн түүнээс элементийн хүхэр үйлдвэрлэх үйлдвэрлэлийн туршилтыг БНХАУ-ын Шинжан Уйгарын ӨЗО-ны Фуоун мужид Шинжаны өнгөт төмөрлөгийн аж үйлдвэр группийн (XJNM) эзэмшлийн Зэс ба никелийн металлургийн "Xinjin Metals" компанийн үйлдвэрлэлийн бүсэд явуулж байна. Тус туршилтын үр дүнгээр "Зэсийн баяжмал хайлуулах, боловсруулах үйлдвэрийн ТЭЗҮ"-д тодотгол хийж холбогдох зөвлөлийн хурлаар хэлэлцүүлэх хүсэлтийг ирүүлээд байна. Тус үйлдвэрийн дэд бүтцийн бүтээн байгуулалтын ажлын хүрээнд ҮТП-ийн асфальт бетон хучилттай 12.62 км авто зам барих ажлын гүйцэтгэл 39%, 4.4 км төмөр зам барих ажлын гүйцэтгэл 85%, Ус хангамж, ариутгах татуургын систем барьж байгуулах ажлын явц 35%, Цахилгаан хангамжийн зураг төсөл боловсруулах ажлын явц 95%-ийн гүйцэтгэлтэй байна	70	Аж үйлдвэр, эрдэс баялгийн яам
				30	2.5.Эрчим хүчний найдвартай эх үүсвэрийг нэмэгдүүлж, дотоодын хэрэгцээг бүрэн ханган, эрчим хүч экспортлох суурь нөхцөлийг бүрдүүлнэ.	2024 онд Дорнодын ДЦС-ын хүчин чадлыг 50 МВт-аар нэмэгдүүлсэн. Амгалан ДС-ын хүчин чадлыг 100 Гкал/ц-аар нэмэгдүүлсэн. Бөөрөлжүүтийн ДЦС-ын 300 МВт-ын төслийн эхний 150 МВт-ын БУА 100% нийт төслийн явц 55%-тай байна. Түүнчлэн хувийн хөрөнгө оруулалтаар Завханы Тосонцэнгэлд 30 МВт-ын ДЦС-ын БУА 95%-тай, Сэлэнгийн 70 МВт-ын, Төв аймгийн Баян сумын нутагт 660 МВт-ын ДЦС-уудын БУА-ыг 2024 онд эхлүүлсэн байна. Сэргээгдэх эрчим хүчний чиглэлээр Ховдын Мянгад суманд 10 МВт-ын, Говь-Алтайн Есөнбулаг суманд 10 МВт-ын, Завхан аймгийн Алдархаан суманд 5 МВт-ын, Говь-Алтайн Алтай суманд 0,3 МВт-ын, Хөвсгөл аймгийн Мөрөн суманд 10 МВт-ын, Дорноговь аймгийн Эрдэнэ суманд 30 МВт-ын ариг цахилгаан станцууд 2022-2024 онд ашиглалтад орсон. Мөн Улаанбаатар хотын Сонгинохайрхан дүүрэгт 80 МВт-ын, Багануур дүүрэгт 50 МВт-ын батарей хуримтлуурын станцууд 2024 онд ашиглалтад орсон. Дээрх төслүүдийн үр дүнд цахилгаан үйлдвэрлэлийн суурилагдсан чадал 265,3 МВт-аар нэмэгдэж байна.	30	Эрчим хүчний яам

		8	2.6.Соёлын бүтээлч үйлдвэрлэлд хөрөнгө оруулалт татаж, соёлын үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлэн соёлын салбарыг эдийн засгийн эргэлтэд оруулна.	50	15	Соёлын бүтээлч үйлдвэрлэлийг дэмжих тухай хуулийн төслийг 2024 оны 05 дугаар сарын 16-ны өдрийн Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанаар батлууллаа. Хууль батлагдсанаар соёлын бүтээлч үйлдвэрлэлийг дэмжих хэлбэр, удирдлага зохион байгуулалтын эрх зүйн үндсийг тогтоохтой холбогдсон харилцааг зохицуулж ""Төр, хувийн хэвшлийн түншлэлээр соёлын бүтээлч үйлдвэрлэлд хамаарах хөрөнгө оруулалт, соёлын бүтээлч үйлдвэрлэлийн кластер, парк, цогцолбор, инкубатор байгуулан ажиллагаагаараа хорших, төрөлжих, хамтран ажиллах нөхцөлийг бүрдүүлэх, экосистем, бүтээлч орон зайг бий болгоход дэмжлэг үзүүлэх"" нөхцөл бүрддээ. Үндэсний статистикийн хорооноос Дотоодын нийт бүтээгдэхүүн 2024 оны хагас жилийн байдлаар гараагүй байна. Соёлын яамнаас 2024 онд зөвхөн кино зураг авалтаас 599.0 сая төгрөгийн хөрөнгө оруулалт татсан. Үүнд: - Гадаадын иргэн, хуулийн этгээд Монгол Улсын нутаг дэвсгэрт зураг авалт хийх зөвшөөрлийг Засгийн газрын 2023 оны ""Улсын тэмдэгтийн хураамжийн хэмжээ тогтоох тухай"" 173 дугаар тогтоолын 9.1.4 дэх хэсэг, Улсын тэмдэгтийн хураамжийн тухай хуулийн 221.1.7 дахь заалтад тус тус тусгагдсаны дагуу татварын албаны төрийн санд 4.7 сая төгрөгийг төвлөрүүлсэн. - Соёлын яамнаас 2024 онд 9 улсын 15 байгууллагад зураг авалтын зөвшөөрөл олгож, Монгол улсын төсөвт 594.3 сая төгрөгийг төвлөрүүлсэн байна. -Кино үйлдвэрлэлийг хөгжүүлж, эдийн засгийн эргэлтийг сайжруулах хүрээнд гадны хөрөнгө оруулалт хийсэн хамтарсан кино бүтээх төслийн хүрээнд монголын нутаг дэвсгэрт кино зураг авалт хийх явцад зарцуулсан зардлын шаардлага хангасан зардалд буцаан олголт олгох хууль, журмыг батлан мөрдүүлж байна. Энэ хүрээнд Монгол, Япон улсын кино уран бүтээлчдийн хамтарсан бүтээл ""Вивант"" телевизийн олон ангит уран сайхны кино бүтээлийг 2023-2024 онд бүтээхэд монголд 13.0 тэрбум төгрөг зарцуулан бүтээгдсэн бөгөөд уг киноны нээлтийн үйл ажиллагаа дэлхийн 18 улсад зохион байгуулсан байна.	50	Соёл, спорт, аялал жуулчлал, залуучуудын яам
		9	2.7.Чөлөөт бүсүүдийн инженерийн дэд бүтцийг хөгжүүлж, хөрөнгө оруулалт татах нөхцөлийг бүрдүүлнэ.	70	16	Монгол Улсын Засгийн газар, Бүгд Найрамдах Франц Улсын Засгийн газар хоорондын "Санхүүгийн хэлэлцээр"-ийг 2024 оны 1 дүгээр сарын 11-ний өдөр УИХ-аар батлуулсан. Онцгой байдлын ерөнхий газрын даргын 2024 оны А/32, А/44 дугаар тушаалаар төслийн гүйцэтгэчийг сонгон шалгаруулах "Үнэлгээний хороо"-г байгуулж, төслийн гүйцэтгэгч БНФУ-ын "Сабена техник хэликоптерс" компанитай 2024 оны 3 дугаар сарын 15-ны өдөр "Худалдааны гэрээ"-г байгуулсан. Гэрээний урьдчилгаа төлбөр болох 3,684,618 еврогийн нэхэмжлэхийг хянан баталгаажуулж, төслийн хүрээнд нийлүүлэгдэж буй ЕС-145 нисдэг тэрэгний 490 төрлийн сэлбэг хэрэгсэл, 20 төрлийн багаж, 18 төрлийн тос, тослох материалг гаалийн болон нэмэгдсэн өртгийн албан татвараас чөлөөлөх ажлыг зохион байгуулан татан авч, мөн эвдрэл гарсан нийт 31 сэлбэг, 3 багажийг буцсан. Агаараас эрэн хайх аврах 111-р ангийн нисгэгчид нийт 65 удаагийн 236 цагийн сургалтын нислэг үйлдсэн ба техникийн албаны 3 албан хаагч /өргөгч төхөөрөмжийн оператор/ 26 удаагийн 67 цагийн өргөгч төхөөрөмжийн нислэг үйлдэх дадлагыг 234 удаа гүйцэтгэж, үүрэг гүйцэтгэх чадваргаа дээшлүүлсэн. Хэлэлцээрийн хүрээнд "Монгол Улсын Онцгой байдлын байгууллагад агаараас аврах ангийг дэд нэмэлт сургалт явуулах төсөл"-ийг 2024-2027 онд 24.7 сая евро буюу 88,104,406,000 төгрөгийн зээлийн санхүүжилтээр хэрэгжүүлэх ба 2024 оны 12 дугаар сарын 19-ний байдлаар 43,188.0 сая төгрөгийг зарцуулсан байна. 2023 оны 11 дүгээр сард хийсэн хэлэлцээрийн урьдчилсан зээлийн тооцоолол 20.0 сая евро ба Улсын хөгжлийн 2024 оны төлөвлөгөөнд 20 сая еврогоор тусуулахаар хүргүүлсэн.	70	Шадар сайд С.Амарсайхан
3	Гурав.Хүний хөгжлийн үзүүлэлтийг сайжруулна.	10	3.1.Олон улсын шаардлагад нийцсэн мэргэжил, ур чадвартай хүний нөөцийг нэмэгдүүлнэ.		17	БЯ:Коосэн сургалтын хөтөлбөрийг аймаг бүрд мэргэжлийн болон техникийн боловсролын сургалтад нэвтрүүлэх зорилгоор Шинжлэх ухаан, технологийн их сургуулийн дэргэдэх Технологийн коллежийг (КООСЭН) Шинжлэх ухаан, технологийн их сургуулийн харьяа Технологийн коллеж болгон өөрчлөн байгуулсан. Энэ хичээлийн жилд нийслэл хотод Шинэ Монгол Технологийн дээд сургууль, Техник, Технологийн Дээд сургууль, ШУТИС харьяа Технологийн коллеж, орон нутагт Өмнөговь аймагт Шинжлэх ухаан, технологийн их сургуулийн харьяа Технологийн дээд сургууль, Орхон аймагт ШУТИС-н "Эрдэнэт цогцолбор" дээд сургуулийн харьяа Эрдэнэт политехник коллеж, Дархан-Уул аймагт ХААИС-н салбар сургууль зэрэг 6 сургалтын байгууллага Коосэн хөтөлбөрийг хэрэгжүүлж байна."Японы Коосэн загварын Технологийн коллежийн хөтөлбөрийг мэргэжлийн болон техникийн боловсрол, сургалтын салбарт нэвтрүүлэх, тогтвортой хөгжүүлэх жишиг загвар"-ыг боловсруулах талаар судалгааны баг ажиллаж, тайланг хүлээлгэж өгсөн. Судалгаа болон бусад бодлогын баримт бичигт нийцүүлэн Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 2.2.2.10-т "Хөдөлмөрийн зах зээлд хүлээн зөвшөөрөгдөхүйц мэдлэг, ур чадвартай төгсөгчдийг бэлтгэх, бус, орон нутгийн хөгжлийн тэргүүлэх чиглэлтэй уялдуулан 5 жилийн сургалттай Коосэн сургалтыг коллеж түшиглэн нэвтрүүлнэ" гэж тусган батлуулсан. Үүнээс гадна мэргэжлийн боловсролын сургууль, политехник коллежид 2024 оны байдлаар Япон Улсын Коосэн сургалтын хөтөлбөрөөс гадна олон улсын дараах хөтөлбөрийг туршин нэвтрүүлээ.1.Англи Улсын Пийрсон-Мэдээллийн технологийн хөтөлбөрийг Ховд, Хөвсгөл, Өмнөговь, Дорнод аймаг дахь Политехник Коллежууд болон УБ хот дахь Үйлдвэрлэл, Урлалын Политехник коллеж, Техник технологийн Политехник Коллеж, Дархан Политехник Коллежид нэвтрүүлж эхэлсэн. Энэ оны хичээлийн жилд тухайн хөтөлбөрөөс нийт 857 суралцагч суурцаж байна.2.Германы хосмог сургалтын хөтөлбөрийг туршин нэвтрүүлж,"Хосмог сургалт, ажлын байран дахь сургалт зохион байгуулах журам"-ыг батлан хэрэгжүүлээ. ГБХНХЯ:Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны эрхлэх асуудалд хамаарахгүй	50	Боловсролын яам, Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам
			3.1.2.Ерөнхий боловсролын сургуулийн сургалтын хөтөлбөр дэх англи хэлний хэрэглээг нэмэгдүүлнэ		18	Засгийн газрын 2024 оны 176 дугаар тогтоолоор баталсан "Сургуулийн өмнөх боловсролын ерөнхий боловсролын сургалтын хөтөлбөрийн үзэл баримтлал"-д нийцүүлэн тус хуулийн 8.2, 9.2-т тус тус заасан агуулгын хүрээнд бага боловсрол сургалтын хөтөлбөр, сурах бичгийг шинэчлэн боловсруулж, тохирц нийцлийг шалган туршиж байна. Туршилтын хүрээнд Боловсролын сайдын 2024 оны А/57 дугаар тушаалаар баталсан бага боловсролын туршилтын сургалтын төлөвлөгөө болон "Англи хэлний цахим системд суурилсан сургалтын хөтөлбөрийг турших, жагсаалт батлах тухай" А/68 дугаар тушаалын дагуу төрийн өмчийн ерөнхий боловсролын 105 сургуулийн 3-4 дүгээр ангид англи хэлний PEARSON цахим системд суурилсан хөтөлбөрийг туршилтаар хэрэгжүүлж, 12000 суралцагч хамрагдаж байна. БШУ-ны сайдын 2023 оны А/338 дугаар тушаалын хүрээнд англи хэлний PEARSON хөтөлбөрийг төрийн өмчийн 105 сургуулийн 5-7 дугаар ангид хэрэгжүүлж, 204,563 суралцагч хамрагдаж байна.	70	Боловсролын яам
			3.1.3.Шаардлагатай эрдэм шинжилгээний өгүүлэл, бүтээл, патентыг эдийн засгийн эргэлтэд оруулна.	72.5	19	ЭЗХЯ:2024 онд технологийн туршилт, зүтгүүлэлтийн 6, докторын дараах инновацийн тэтгэлэг 10, орон нутгийн инновацийн үйл ажиллагааг дэмжих "МонХ" хөтөлбөрийн хүрээнд 9 төслийг тус тус хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлсэн. ХЗДХЯ: Тус яамны харьяа Дотоод хэргийн Их сургууль нь 2024-2025 оны хичээлийн жилийн элсэлтээр дэд бакалаар, бакалаврын 8 хөтөлбөрт 544 суралцагч, магистрын 14 хөтөлбөрт 130 суралцагч, докторын 6 хөтөлбөрт 41, нийт 975 иргэнийг элсүүлсэн байна. Боловсролын багц хууль, Дээд боловсролын сургалтын хөтөлбөрт тавих шаардлагын дагуу Их сургуулийн хөтөлбөрийн шинэчлэлийг хийж, 3+1+1 буюу дэд бакалаврын түвшинд 90 багц цагийг 3 жил судлах, нэг жил үйлдвэрлэлийн дадлага хийх, нэг жил мэргэшүүлэх 30 багц цагийг судалж бакалаврын боловсрол эзэмших хөтөлбөрт анх удаа шинээр элсэлт авч сургалтыг зохион байгуулж байна. Дээд боловсролын иргэдэд зориулсан хоёр жилийн мэргэшүүлэх бакалаврын хөтөлбөрийг сурталчлах уулзалт, өдөрлөгийг 2024 оны 11 дүгээр сарын 18-27-ны өдрүүдэд төрийн өмчит 5 их сургуульд амжилттай зохион байгууллаа. Их сургуулийг түшиглэсэн Докторын зэрэг хамгаалуулах зөвлөл нийт 50 удаагийн хуралдаан зохион байгуулж, 25 докторант докторын зэргээ амжилттай хамгаалснаас 10 нь Дотоод хэргийн их сургуулийн багш, албан хаагч байна. Хууль зүйн үндэсний хүрээлэнтэй хамтран Хууль зүй, дотоод хэргийн сайдын нэрэмжит эрдэм шинжилгээний "Шилдэг бүтээл", "Оюутны шилдэг илтгэл", "Грант олгох төсөл"-ийн уралдааныг амжилттай зохион байгуулж, шилдгээр шалгарсан бүтээлийн эздэд 2024 оны 11 дүгээр сарын 20-ны өдөр шагналыг гардуулсан. Тус уралдаанд 27 бүтээл, 27 илтгэл, 20 төсөл ирүүлсэнээс "Шилдэг бүтээл"-ийн төрөлд Дотоод хэргийн Их сургуулийн 7 багш, албан хаагчийн бүтээл тусгай байрт, "Шилдэг илтгэл"-ийн төрөлд 2 сонсогчийн бүтээл гуравдугаар байр, тусгай байрт тус тус шалгарч, "Грант олгох төсөл"-ийн хавсарга судалгааны төрөлд 1 профессорын илтгэл шалгарсан амжилттай оролцсон. Их сургуулийн багш, албан хаагчид Оюуны өмчийн газраас 2024 онд зохиогчийн эрхийн гэрчилгээ 5, ашигтай загварын гэрчилгээ 1, нийт зохиогчийн эрхийн гэрчилгээ 25, ашигтай загварын гэрчилгээ 3, барааны тэмдэг 1-ийг тус тус авсан.	100	Эдийн засаг, хөгжлийн яам, Хууль зүй, дотоод хэргийн яам,
			3.1.4.Боловсролын салбарын хүртээмжийг нэмэгдүүлэх хөрөнгө оруулалтыг хийнэ.		20	Боловсролын салбарт 2024 оны төсвийн жилд улсын төсвийн хөрөнгө оруулалтын нийт 2.221.8 тэрбум төгрөгийн төсөвт өртөг бүхий 440 төсөл, арга хэмжээ хэрэгжсэн бөгөөд үүнд 69410 хүүхдийн хүчин чадал бүхий 156 сургуулийн барилга, 21970 хүүхдийн хүчин чадал бүхий 148 цэцэрлэгийн барилга, 5570 хүүхдийн хүчин чадал бүхий 41 дотуур байрны барилга, 22 сургуулийн спорт зал барихаар төлөвлөн ажилласан. 2024 төсвийн жилд Монгол Улсын Ерөнхий сайдаас өгөгдсөн 100 хоногт хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөөнд тусгагдсан 3 ээлжийн сургуулийг 2 ээлж рүү оруулах зорилт, Засгийн газрын 2024 оны 11 дүгээр сарын 13- ны өдрийн 169 дүгээр тогтоолын хэрэгжүүлэх, боловсролын салбарын хүртээмжийг нэмэгдүүлэх хүрээнд ашиглалтад орох боломжтой нийслэлийн 10 сургуулийн барилгын шаардлагатай санхүүжилтийг Боловсролын сайдын 2024 оны 6 дугаар сарын 7-ны өдрийн А/295 дугаар тушаалаар санхүүжилтийн зохицуулалтад оруулж 2024-2025 оны шинэ хичээлийн жил эхлэхээс өмнө ашиглалтад оруулж ажиллаж сургуулийн байргүй, түрээсийн байранд хичээллэж байгаа 5840 хүүхдийн хүчин чадалтай 10 сургуулийн байрыг ашиглалтад оруулснаар шийдвэрлэсэн. Ингээд 2024 оны жилийн эцсийн байдлаар улсын хэмжээнд 13300 хүүхдийн 28 сургууль, цогцолборын барилга, 4745 хүүхдийн 33 цэцэрлэгийн барилга, 1200 хүүхдийн 11 дотуур байрны барилга, 3 сургуулийн спорт заалны барилга тус тус улсын комисс ажиллаж байнгын ашиглалтад ороод байна.	70	Боловсролын яам
			3.2.Нийгмийн хамгааллын салбарт нийгмийн даатгалын оновчтой тогтолцоог бий болгох, төрийн албан хаагчдын цалинг үе шаттайгаар нэмэгдүүлэх, нийгмийн зорилтот бүлгийг зөв тодорхойлж, нийгмийн халамжийн сангаас олгох тэтгэвэр, тэтгэмжийн хэмжээг нэмэгдүүлэн нийгмийн баталгааг сайжруулна.		21	Нийгмийн даатгалын багц хуулийн төслийг шинэчлэн боловсруулж 2023 оны 07 дугаар сарын 07-ны өдөр Улсын Их Хурлаас баталсан. Багц хуулийн шинэчлэлийн хүрээнд өмнөх үеийн цалин, хөлс түүнтэй адилтгах орлогын өнөөгийн үнэ цэнийг тодорхойлох итгэлцүүрийг жил бүрийн 8 дугаар сарын 1-ний өдөр шинэчлэн баталж байхаар тусгасан. Түүнчлэн Засгийн газрын 2023 оны 238 дугаар тогтоолоор тэтгэвэр бодох цалингийн итгэлцүүрийг 9 жилийн дараа шинэчлэн баталж ижил ажил мэргэжлээр ойролцоо жил ажиллаж, шимтгэл төлсөн тэтгэвэр авагчдын тэтгэврийн зөрүүг ойртуулсан. Мөн Засгийн газрын 2024 оны 10 дугаар тогтоолоор 2024 онд хэрэглэх итгэлцүүрийг баталсан. 2025 онд хэрэглэх "Итгэлцүүр батлах тухай" Засгийн газрын тогтоолын төслийг боловсруулан бүх яамдаас санал авч нэгтгэн Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлж, батлуулахаар Засгийн газрын хэрэг эрхлэх газарт хүргүүлсэн. Ингэснээр даатгуулагч өнөөгийн үнэ цэнээр илэрхийлэгдсэн тэтгэвэр тогтооногдох эрх зүйн орчин бүрдсэн.	70	Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам
			3.2.2.Үр дүнд суурилсан удирдлагын нэгдсэн тогтолцоог бүрэн нэвтрүүлэн, төрийн албаны бүтцийн шинэчлэлийг хийж, төрийн албан хаагчдын цалин хөлсийг ажлын бүтээмж, үр дүнтэй уялдуулан нэмэгдүүлнэ.		22	ГБХНХЯ:Төрийн албан хаагчдын үндсэн цалинг инфляцын түвшинтэй уялдуулан нэмэгдүүлэх зарчмыг баримтлан 2024 оны 04 дүгээр сарын 01-ний өдрөөс төрийн нийтлэг үйлчилгээний албан хаагчдын үндсэн цалинг 20 хувиар, бусад төрийн албан хаагчдын цалинг 10 хувиар нэмэгдүүлэх асуудлыг Засгийн газрын 2024 оны 03 дугаар сарын 27-ны өдрийн 128 дугаар тогтоолоор батлуулав. 2.Орон нутгийн нэмэгдлийг 2024 оны 04 дүгээр сарын 01-ний өдрөөс хөдөөгийн суманд ажиллаж байгаа төрийн захиргааны, үйлчилгээний болон улс төрийн албан тушаал эрхэлдэг албан хаагчид үндсэн цалингийн 40 хувиар, харин аймгийн төв болон нийслэлийн алслагдсан гурван дүүрэгт ажиллаж байгаа төрийн албан хаагчдад үндсэн цалингийн 20 хувиар тооцож олгохоор холбогдох журмыг Засгийн газрын 2024 оны 02 дугаар 28-ны өдрийн 82 дугаар тогтоолоор шинэчлэн батлуулав. ЗГХЭГ:1.Төрийн албаны шинэчлэлийн хүрээнд Засгийн газраас Төрийн албаны цалин хөлсний бүтэц, цалингийн тогтолцооны шинэчлэлийг 2023 оноос эхлүүлсэн. Уг зорилтыг үргэлжүүлэн төрийн албан хаагчдын цалин хөлсийг инфляцын түвшинтэй уялдуулан 2024 оны 04 дүгээр сарын 01-ний өдрөөс нэмэгдүүлсэн. 2.БНСУ, Австралийн Холбооны Улсын төрийн албаны үр дүн, гүйцэтгэлд суурилсан цалин хөлсний тогтолцоог судалсны дагуу 2023 онд шинэчилэн боловсруулсан Төрийн жинхэнэ албан хаагчийн гүйцэтгэлийн төлөвлөгөөг боловсруулж батлах, ажлын гүйцэтгэл, үр дүн, мэргэшлийн түвшинг үнэлэх журмын дагуу төрийн жинхэнэ албан хаагчдын ажлын гүйцэтгэлийг үр дүнтэй нь уялдуулан үнэлж, урамшуулах ажлыг 3 дахь удаагаа зохион байгууллаа. 3.Үр дүнд суурилсан удирдлагын нэгдсэн тогтолцоог нэвтрүүлэх хүрээнд ТАХ-ийн гүйцэтгэлийн удирдлагын цахим системийг хөгжүүлэх зорилт тавьж БНСУ-ын буцалтгүй тусламжаар "Гүйцэтгэлийн үнэлгээний нэгдсэн цахим систем"-ийг хөгжүүлж, нэвтрүүлэх ажлыг БНСУ-ын талаас "NexIn" компани, туслан гүйцэтгэгчээр "Spinaweb" гэх дотоодын компани хариуцан ажиллаж байна. Систем хөгжүүлэлтийн ажлыг эрчимжүүлэх чиглэлд захиалагч талаас олон удаагийн уулзалт, хурлыг хөгжүүлэлт тусгай зохион байгуулж, хөгжүүлэлтийн явцад тогтмол холбоотой ажиллаж байна. Гэсэн хэдий ч систем хөгжүүлэлтийн гүйцэтгэл 2024 оны 12 дугаар сарын байдлаар 73%-тай байгаа бөгөөд системийг бүрэн төстлөх, холбогдох техник хангамжийг хүлээн авч, суурилуулах ажил хүлээгдэж байна./80/	50	Төрийн албаны зөвлөл, Засгийн газрын Хэрэг эрхлэх газар, Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам

				66.0	23	3.2.3.Цалинг цагаар тооцдог системд бүрэн шилжинэ.	ГБНХЯ:Хөдөлмөр, нийгмийн түншлэлийн гурван талт үндэсний хорооны 2023 оны 10 дугаар сарын 13-ны 12 дугаар тогтоолоор улсын хэмжээнд мөрдөх хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг 2024 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн сард 660.0 мянган төгрөгөөр шинэчлэн тогтоолоо. Цалинг цагаар тооцоходо хөдөлмөрийн хөлсний доод хэмжээнээс багагүй байхаар тогтооно. Хөдөлмөр, нийгмийн түншлэлийн гурван талт Үндэсний хорооны 2023 оны 02 дугаар тогтоолоор "Ажлын бүтэн бус цагаар ажиллуулах хөдөлмөрийн гэрээний болон цагийн ажлын гэрээний үлгэрчилсэн загвар"-ыг баталсан. Цагийн ажилтан ажил олгогч хоёрын хооронд Хөдөлмөрийн тухай хуулийн 66 дугаар зүйлд заасан "Ажлын бүтэн бус цагаар ажиллуулах хөдөлмөрийн гэрээ" байгуулагддаг. Цагийн ажилтан нь Хөдөлмөрийн тухай хуульд тусгайлан зааснаас бусад тохиолдолд ажлын бүтэн цагаар ажиллах ажилтны нэгэн адил эрх эдэлж, үүрэг хүлээх бөгөөд хөдөлмөрийн хууль тогтоомж, хамтын гэрээ, хамтын хэлэлцээр, хөдөлмөрийн дотоод хэм хэмжээ нэгэн адил үйлчилнэ. Ажлын бүтэн бус цагаар ажиллах хөдөлмөрийн гэрээнд ажлын байрны нэр, ажлын байрны тодорхойлолтод заасан гүйцэтгэх ажил үүрэг; ажил үүрэг гүйцэтгэх байршил; цалин хөлсний хэмжээ; хөдөлмөрийн нөхцөл зэргийг тусгана. - ажил, амралтын цаг, цалин хөлс олгох журам; хөдөлмөрийн гэрээг цуцлах, дуусгавар болгох үндэслэл; хөдөлмөрийн сахилга, гомдол гаргах талаар тусгана. Ажлын байранд тавигдах ур чадвар, чадамжийн шаардлага, долоо хоногт, эсхүл сард ажиллах нийт цаг, ажил эхлэх, дуусах цагийг тусгайлан тохирно. Ажил олгогч түр ажил үүргийг гүйцэтгүүлэхээр ажилтныг цагаар ажиллуулж, гүйцэтгэсэн ажил, ажилласан цаг нь тохирсон цалин хөлсийг тухай бүр тооцож олгож болно.	70	Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам, Сангийн яам
				66.0	24	3.2.4.Нийгмийн халамжийн системийг шинэчлэн, халамж зайлшгүй хүртэх зорилтот бүлгийг оновчтой тодорхойлж, халамжийг зөвхөн тусгайлан картаар олгоно	Нийгмийн халамжийн тухай хууль, тогтоомжийн дагуу нийгмийн даатгалын сангаас тэтгэвэр, тэтгэмж авах эрх үүсээгүй ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй иргэн, тэжээгч нь нас барсан 18 хүртэл насны хүүхэд, өрх толгойлсон эх, эцэгт нийгмийн халамжийн сангаас тэтгэвэр олгож байна. Мөн байнгын асаргаа шаардлагатай ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй иргэн, хүүхдийг асарч байгаа иргэдэд асаргааны тэтгэмжийг сар бүр олгодог. Нийгмийн халамжийн тэтгэвэр, тэтгэмжийг хүн амын бүлэгт суурилсан аргаар зорилтот бүлгийг тодорхойлон олгож байна. "Нийгмийн халамжийн нэгдсэн систем" буюу "ehalamj" –ийг хөгжүүлж, нэвтрүүлэх ажлыг хэрэгжүүлж байна. Тус ажлын хүрээнд дараах арга хэмжээг авч хэрэгжүүлсэн. Үүнд: - Ehalamj "Нийгмийн халамжийн нэгдсэн систем"-ийг 2020 оны 8 дугаар сарын 26-ны өдрөөс улсын хэмжээнд нэвтрүүлсэн. Одоогоор Нийгмийн халамжийн 68 төрлийн үйлчилгээнээс 64 үйлчилгээг буюу нийт үйлчилгээний 72 хувийг цахим хэлбэрт шилжүүлсэн бөгөөд иргэд нийгмийн халамжийн үйлчилгээг 100 хувь картаар авч байна. - Нийгмийн халамжийн тухай хуулийн 22.1.1-д заасан хүнсний хангамж зайлшгүй шаардлагатай өрхийн гишүүн-иргэн хүнс тэжээлийн дэмжлэг үзүүлэх үйлчилгээг Төрийн банкны тусгайлан картаар олгож байна. Уг ажлын хүрээнд Хүнсний эрхийн бичгээр үйлчлэх дэлгүүрт кассын системийн хөгжүүлэлт хийлгэж, зөвхөн журамд заасан 10 нэр төрлийн хүнсний бүтээгдэхүүнийг худалдан авсан тохиолдолд картыг унших тохиргоотой болгоосон. - Иргэд e-mongolia https://e-mongolia.mn/services/citizen/sector/all , ehalamj.mn https://www.ehalamj.mn/ цахим хуудас, төрийн үйлчилгээний цахим машин "ТУЦ" машин, ebarimt https://ebarimt.mn/ аппликейшн ашиглан нийгмийн халамжийн үйлчилгээнд хамрагдах хүсэлтээ гаргаж, үйлчилгээг бүрэн авах боломжтой болсон.	70	Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам
				66.0	25	3.2.5.Тэтгэвэр, тэтгэмжийг инфляцын түвшинтэй уялдуулан нэмэгдүүлнэ.	Нийгмийн даатгал: Монгол Улсын Засгийн газраас хүн амын амьжиргааны өртгийн өөрчлөлттэй уялдуулан 2018, 2019, 2020, 2022, 2023, 2024 онуудад нийгмийн даатгалын сангаас олгох бүх төрлийн тэтгэврийн хэмжээг нэмэгдүүлж, дундаж тэтгэврийн хэмжээ 2016 онд 310.7 мянган төгрөг хүргэж 2.5 дахин нэмэгдүүлсэн. Тухайлбал, Монгол Улсын Засгийн газрын 2024 оны 03 дугаар сарын 20-ны өдрийн 120 дугаар тогтоолоор Нийгмийн даатгалын сангаас олгож байгаа болон цэргийн тэтгэвэр авагчийн авч байгаа тэтгэврийн хэмжээг 100 мянган төгрөгөөр нэмэгдүүлж, хувь тэнцүүлсэн тэтгэврийн доод хэмжээг 540 мянга, бүрэн тэтгэврийн доод хэмжээг 650 мянган төгрөгт хүргэж нэмэгдүүлсэн. Түүнчлэн УИХ-аас Нийгмийн даатгалын багц хуулийн төслийг 2023 оны 07 дугаар сарын 07-ны өдөр баталсан бөгөөд хуульд тэтгэврийн хэмжээг инфляцын түвшинтэй уялдуулан 2025 оноос эхлэн жил бүрийн 01 дүгээр сарын 01-ний өдрөөс нэмэгдүүлэх зохицуулалт тусгаж нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэврийн хэмжээг үе шаттай нэмэгдүүлэх эрх зүйн орчинг бүрдүүлсэн. Нийгмийн халамж: Нийгмийн даатгалын сангаас тэтгэвэр авах эрх үүсээгүй ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй иргэн, тэжээгч нь нас барсан хагас болон бүтэн өнчин хүүхдүүд гэх зэрэг нийгмийн зүгээс анхаарал халамж зайлшгүй шаардлагатай 59.4 мянган иргэн нийгмийн халамжийн тэтгэвэр авч байна. Мөн 2014 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс 16 хүртэлх насны байнгын асаргаа шаардлагатай хөгжлийн халамжийн тэтгэвэртэй тэнцүү хэмжээгээр тусламж олгох болсон бөгөөд энэ тусламжид 2024 онд нийт 14.1 орчим мянган хүүхэд хамрагдсан байна. Монгол Улсын Засгийн газар 2024 оны 04 дүгээр сарын 01-ний өдрөөс нийгмийн халамжийн тэтгэврийн хэмжээг 375,000 төгрөг, асаргааны тэтгэмжийн хэмжээг 302,500 төгрөг болгон нэмэгдүүлсэн. 2024 оны 10 дугаар сарын мэдээгээр нийгмийн халамжийн тэтгэвэр, тэтгэмжид нийт 381.4 тэрбум төгрөг зарцуулсан байна.	70	Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам
			12		26	3.3.1.Дотоодод худалдаалж байгаа эмийн чанарыг олон улсын стандартад нийцүүлнэ.	УИХ-ын 2023.06.16-ны өдрийн нэгдсэн хуралдаанаар Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн шинэчилсэн найруулгыг баталсан ба хуулийн 36.1.2-т олон улсын чанарын шаардлага хангасан хүний эмийг гадаад улсын үйлдвэрлэгчээс, эсхүл олон улсын байгууллага, эмийн зохицуулалтын үнэлгээгээр ДЭМБ-аас хүлээн зөвшөөрөгдсөн эмийн зохицуулалтын эрх бүхий байгууллагатай гадаад улсаас шууд болон дамжуулан худалдан авах бол нэг эх үүсвэрээс худалдан авах аргыг хэрэглэхээр зохицуулсан. Улмаар Засгийн газрын 2024 оны 42 дугаар тогтоолоор "Олон улсын чанарын шаардлага хангасан хүний эм, эмнэлгийн хэрэгсэл, биобэлдмэл, вакциныг гадаад улсын үйлдвэрлэгчээс, эсхүл олон улсын байгууллагаас шууд болон дамжуулан худалдан авах журам" батлагдсан. УИХ-ын 2024 оны 06 дугаар сард батлагдсан Эм, эмнэлгийн хэрэгслийн тухай хуулийн шинэчилсэн найруулгад дотоодын эмийн үйлдвэрийн бүтээгдэхүүний чанарыг олон улсын стандартад нийцүүлэх бодлогын хүрээнд үндэсний эмийн үйлдвэрлэгчид Эм үйлдвэрлэлийн зохиистой дадалгйг бүрдүүлж, иргэд эх орондоо бүрэн оношлогдон эмчлэгдэх боломжийг бүрдүүлэх зорилгоор Эрүүл мэндийн салбарт UpToDate олон улсын тусламж, зохицуулалтын эрх бүхий байгууллага, чихрийн шижин болон хавдрын хими эмчилгээний эмүүдийг Монгол Улсад нийлүүлэх хэлэлцээрүүд үргэлжилж байна. Үүний үр дүнд БНСУ-ын Dongkoo Bio & Pharm эмийн үйлдвэртэй ЭМЯ, ЭЭХХЗГ хамтын ажиллагааны гэрээ 2024.11.22-ны өдөр байгуулж, 5 нэрийн эмийг нэг эх үүсвэрээс худалдан авах ажиллагаа эхэлсэн. Хатуу эмийн зохицуулалттай улсуудаас олон улсын чанарын шаардлага хангасан эм Монгол Улсад оруулж ирснээр эмийн үнийг 50 хүртэл % бууруулах боломж бүрдэх юм.	90	Эрүүл мэндийн яам, Шадар сайдын ажлын алба
			63.9		27	3.3.2.Эрүүл мэндийн үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлэх хөрөнгө оруулалтыг хийнэ	ЭМЯ:Эрүүл мэндийн үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлэх хүрээнд Сурьээгийн эмнэлэг, Эрхтэн шилжүүлэн суулгах төв, Хавдар судлалын үндэсний төвийн салбар II, Баянзүрх дүүргийн нэгдсэн эмнэлгийн барилга барих арга хэмжээнүүдийг төлөвлөгөөнд тусгагдсан ч санхүүжилтийн эх үүсвэр шийдэгдэхгүй байснаас "Үр дүнгүй" болон "Эрчимжүүлэх шаардлагатай" үнэлгээтэй байна. Оношилгоо, эмчилгээний орчин үеийн дэвшилтэт технологийг нэвтрүүлж, иргэд эх орондоо бүрэн оношлогдон эмчлэгдэх боломжийг бүрдүүлэх зорилгоор Эрүүл мэндийн салбарт UpToDate олон улсын тусламж, үйлчилгээний удирдамжийн цахим платформийг нэвтрүүлэн, эмнэлгийн нэгдсэн эмнэлгийн тасралтгүй сургалтын багц цагийн 1/3-ийг платформоос бүрдүүлэх боломжтой болсон. 2024 онд нийт 41 оношилгоо, эмчилгээний эмнэлзүйн зааврыг Эрүүл мэндийн сайдын тушаалаар батлуулж, хэрэгжүүлж байна. Эрүүл мэндийн мэдээллийн "Health-ESB" санд анхан шатны эрүүл мэндийн 535, лавлагаа шатлалын 48, хувийн хэвшлийн 100 гаруй эрүүл мэндийн байгууллагыг цахим технологи ашиглан хоорондоо мэдээлэл солилцох боломжийг бүрдүүлж, "Эмийн цахим жор"-ыг нээж, Эрүүл мэндийн даатгалын ерөнхий газартай гэрээтэй болон e-barimt системтэй холбогдсон 2,100 эмийн сан, 800 гаруй эмнэлэг Эрүүл мэндийн мэдээлэл солилцооны систем HEALTH-ESB-д холбогдсон. Монгол Улсад эмчлэх боломжгүй байсан 26 өвчний жагсаалтаас 1 өвчнийг (Дутуу нярайн торлогийн эмгэгийн улмаас торлог ховхрох үеийн торлог шилэнцрийн мэс засал) эмчлэх шинэ технологи нэвтрүүлэн нутагшуулсан тул жагсаалтаас уг өвчний хасаж, 25 өвчин болгож, гадаад улсад оношилгоо, эмчилгээ хийлгэхэд 79 иргэнд 2,898,997,810.12 төгрөгийн санхүүгийн дэмжлэгийг үзүүлжээ. 13 үндэсний багийг байгуулж, гадаадын өндөр хөгжилтэй оронд чадавхжуулах сургалтад хамруулж, орон нутагт ажиллаж, техник технологи нутагшуулахад анхаарч байна. Мөн зайн оношилгооны үйлчилгээг орон нутагт үзүүлэх боломжийг хөгжүүлж, 2024 онд нийт 59 эрүүл мэндийн байгууллагыг телемедицинд холбож, цаг алдалгүй зөвлөгөө, тусламжийг үзүүлж байна. СЯ:2024 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн 2-р хавсралтад Эрүүл мэндийн сайдын багцад 282.6 тэрбум төгрөг батлагдсанаас эмнэлгийн барилга барихад 200.2 тэрбум төгрөг, их засварын ажилд 24.8 тэрбум төгрөг, тоног төхөөрөмж худалдан авахад 57.6 тэрбум төгрөг тус тус батлагдсан. 2024 оны 12-р сарын 20-ний өдрийн байдлаар 128.6 тэрбум төгрөгийн санхүүжилт олгоод байна. УИХ-аар баталсан 2025 оны төсвийн тухай хуульд Эрүүл мэндийн сайдын багцад 433.6 тэрбум төгрөг батлагдсан.	30	Эрүүл мэндийн яам, Сангийн яам
					28	3.3.3.Нийтийн тамир, спортын үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлэх хөрөнгө оруулалтыг хийнэ.	Нийтийн биеийн тамир, спортын үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлэх хөрөнгө оруулалтын чиглэлээр 2024 оны жилийн эцсийн байдлаар спортын салбарт - Дархан-Уул аймгийн 2200 хүний суудал бүхий 2 заал, усан бассейн цогцолборыг ашиглалтад оруулж байнгын ашиглалтад хүлээн авсан, -Баянгол дүүргийн усан бассейн бүхий спорт заалны барилга, - Налайх дүүргийн 700 суудалтай спорт цогцолборын барилга, - Сүхбаатар аймгийн Баруун-Урт суманд байрлах спортын заалны барилга, - Баянхонгор аймгийн спорт заалны барилга, - Говь-Алтай Бугат сумын спорт заалны барилга, -Увс аймгийн Хяргас сумын спорт заалны барилга, - Баянхонгор аймгийн Шинэжинэст сумын спорт заалны барилгуудыг 100 хувь дуусган байнгын ашиглалтад хүлээн авсан. Мөн Спортын анагаах ухаан эрдэм шинжилгээний төв болон нийт орон нутаг, нийслэлийн 11 дүүргийн БТСГ-т 2.9 тэрбум төгрөгийн тоног төхөөрөмж нийлүүлсэн.	71.8	Биеийн тамир, спортын улсын хороо
4	Дөрөв.Аялал жуулчлалыг хөгжүүлнэ.	13	4.1.Аялал жуулчлалын салбарын бүтээгдэхүүний нэр төрлийг нэмэгдүүлэх, дэд бүтцийн хөрөнгө оруулалтыг түлхүү хийнэ. Мөн агаарын тээврийг либералчлан, нислэгийн тоо өсгөж, жуулчдын тоо, аялал жуулчлалын салбарын орлогыг нэмэгдүүлнэ.		29	4.1.1.Аялал жуулчлалын бус нутгуудад авто замын дэд бүтцийн чанар, хүртээмжийг сайжруулах хөрөнгө оруулалтыг хийнэ.	ЗТЯ:Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 2024 онд нийт 583.8 км замын барилгын ажил хийж, Улаанбаатар-Чингис хот чиглэлийн авто замаас Өмнөдэлзэр сум хүртэлх хатуу хучилттай авто зам 52.5 км, Өндөрхаан-Норовлин чиглэлийн 20 км, нийт 72,5км замыг 2024 онд ашиглалтад оруулж хөдөлгөөн нээв. Монгол Улсын Засгийн газраас 2023-2025 оныг Монголд зочлох жил болгон зарласантай холбогдуулан Аялал жуулчлалын гол чиглэлийн авто зам дагуух ногоон шийдэлтэй "Авто замын дагуух үйлчилгээний цогцолбор. Ерөнхий шаардлага" MNS 5537:2016 стандарт шаардлага хангасан улсын хэмжээнд улс, олон улсын чанартай авто замын дагуу зорчигчид, жуулчдын үйлчилгээнд зориулагдсан нийт 24 үйлчилгээний цогцолбор үйл ажиллагаа явуулж байна. Үүний дээр Өвөрхангай, Завхан, Булган, Дорноговь, Дархан-Уул, Хэнтий, Ховд аймгуудад төр, хувийн хэвшлийн хамтын ажиллагааны хүрээнд уг стандартын шаардлагыг хангасан 10 аж ахуйн нэгж, байгууллагатай "Автотээврийн үндэсний төв" ТӨҮГ гэрээ байгуулан хамтран ажиллаж зорчигч, аялагчдад тав тухтай, түргэн шуурхай үйлчилгээг үзүүлж байна. Түүнчлэн иргэдийн зорчин явах тав тухтай байдал, эрэлт хэрэгцээг хангах ажлын хүрээнд орон нутгийн зорчигч тээврийн үйлчилгээнд явж буй 310 автобусанд буюу тээврийн нэгдсэн системд бүртгэлтэй 628 автобусны 50 хувьд нь, мөн хотын доторх нийтийн тээврийн үйлчилгээний автобусны 54 хувьд буюу 600 автобусанд WIFI төхөөрөмж суурилуулсан зорчигчид интернэт сүлжээ ашиглах боломжийг бүрдүүлсэн нь олон нийтийн талархлыг хүлээсэн ажил боллоо. Үүний үр дүнд автотээврийн орон нутгийн зорчигчдын тоо 2024 оны 12 дугаар сарын 08-ний өдрийн байдлаар 1.68 саяд хүрч, өмнөх оны мөн үеэс 18 хувиар өслөө. Түүнчлэн 2024 онд улс хоорондын зорчигч тээврийн үйлчилгээний чиглэлээр Хавирга-Ар хашаатын боомт, Ханги-Мандалын боомт, Шивээхүрэн-Сэхээгийн боомтоор зорчигчийн тогтмол бус тээвэрлэлтийг эхлүүлж 124 мянган зорчигч тээвэрлэсэн бол оны эхний 11 сарын байдлаар нийт 727 мянган зорчигчид улс хоорондын автотээврийн үйлчилгээг үзүүлжээ.ССАЖЗЯ:Үндсэн хэрэгжүүлэгч байгууллага нь Зам, тээврийн хөгжлийн яам бөгөөд агаарын тээврийг либералчлан, нислэгийн тоо өсгөж, жуулчдын тоо, аялал жуулчлалын салбарын орлогыг нэмэгдүүлэх чиглэлээр дараах арга хэмжээг зохион байгуулсан. Аялал жуулчлалын бүтээгдэхүүнийг нэмэгдүүлэх ажлын хүрээнд 2024 оны аялал жуулчлалын нэгдсэн арга хэмжээний цагалбарыг гарган гадаад улсад болон дотоодод сурталчлах арга хэмжээг хийж байна. Монгол улсыг зорин ирсэн жуулчны тоо нь 2024 оны 12 сарын байдлаар 793,880 жуулчин ирсэн бөгөөд жуулчдын ирсэн бөгөөд аялал жуулчлалын салбарын орлого болон 1.5 тэрбум ам долларын орлого олоод байна. Аялал жуулчлалын бүтээгдэхүүний нэр төрлийг нэмэгдүүлэх ажлын хүрээнд Монгол Улсын Засгийн газрын 2023 оны 12 дугаар сарын 19-ны өдрийн хуралдаанаар батлуулсан 2024 оны эвентийн календарийн дагуу арга хэмжээний хэрэгжилтийг хангаж ажилласан. Үндэсний бахархал, Монгол өв соёлыг өвлүүлэх, үндэсний дархлаа бий болгох аялал жуулчлалын шинэ бүтээгдэхүүн бий болгох зорилтын хүрээнд: - Архангай аймагт "АРА фестиваль", "Улаанбаатар олон улсын медиа урлагийн наадам", "Нүүдэлчин дэлхийн фестиваль", "Бүргэдийн баяр", "Бодибилдингийн фитнесийн ази тивийн аварга шалгаруулах тэмцээн", "Агтана хүрээт хүлэгч эрсийн наадам", "Хар хорин айс фестиваль" зэргийг дэмжин хамтран ажилласан. - Үндэсний их баяр наадмыг тэмдэглэн өнгөрүүлэх хүрээнд сур харвааны ажлын хэсэгт ажиллахаас гадна жуулчдад зориулан наадмын нээлтийн арга хэмжээг орой тоглуулах арга хэмжээг зохион байгуулсан. Мөн олон улсын авто зам дагуу 200 км тутамд үйлчилгээний цогцолбор барих газрын жагсаалтыг 2024 оны 05 дугаар сарын 01-ний өдрийн 189 дугаар тогтоолоор батлуулсан.	30	Зам, тээврийн яам, Соёл, спорт, аялал жуулчлал, залуучуудын яам
				70					

				30	4.1.2.Аялал жуулчлалыг дэмжсэн зөөлөн дэд бүтцийн бодлогын арга хэмжээг хэрэгжүүлж, жуулчдад зориулсан бүтээгдэхүүний нэр төрлийг нэмэгдүүлнэ.	Аялал жуулчлалын бүтээгдэхүүнийг нэмэгдүүлэх ажлын хүрээнд 2024 оны аялал жуулчлалын нэгдсэн арга хэмжээний цагалбарыг гарган гадаад улсад болон дотоодод сурталчлах арга хэмжээг хийж байна. Монгол улсыг зорин ирсэн жуулчны тоо нь 2024 оны 12 сарын байдлаар 793,880 жуулчин ирсэн бөгөөд аялал жуулчлалын салбарын орлого нь 1.5 тэрбум ам долларын орлого олоод байна. Аялал жуулчлалын бүтээгдэхүүний нэр төрлийг нэмэгдүүлэх ажлын хүрээнд Монгол Улсын Засгийн газрын 2023 оны 12 дугаар сарын 19-ны өдрийн хуралдаанаар батлуулсан 2024 оны эвентийн календарийн дагуу арга хэмжээний хэрэгжилтийг хангаж ажилласан. Үндэсний бахархал, Монгол өв соёлыг өвлүүлэх, үндэсний хавсралтаа бий болгох аялал жуулчлалын шинэ бүтээгдэхүүн бий болгох зорилтын хүрээнд: - Архангай аймагт ""АРА фестиваль"", "Улаанбаатар олон улсын медиа урлагийн наадам", "Нүүдэлчин дэлхийн фестиваль", "Бүргэдийн баяр", "Бодибилдингийн фитнесийн ази тивийн аварга шалгаруулах тэмцээн", "Агтана хүрээт хүлэгч эрсийн наадам", "Хар хорин айс фестиваль" зэргийг дэмжин хамтран ажилласан. - Үндэсний их баяр наадмыг тэмдэглэн өнгөрүүлэх хүрээнд сур харвааны ажлын хэсэгт ажиллахаас гадна жуулчдад зориулан наадмын нээлтийн арга хэмжээг орой тоглуулах арга хэмжээг зохион байгуулсан. Мөн олон улсын авто зам дагуу 200 км тутамд үйлчилгээний цогцолбор барих газрын жагсаалтыг 2024 оны 05 дугаар сарын 01-ний өдрийн 189 дугаар тогтоолоор батлуулсан.	90	Соёл, спорт, аялал жуулчлал, залуучуудын яам
				31	4.1.3.Агаарын тээврийг либералчлан, Дорнод, Ховд, Хөвсгөл аймгийн нисэх буудлыг 4С, Өмнөговь аймгийн нисэх буудлыг 4D ангиллын агаарын хөлөг хүлээн авах аэродром, зорчигч үйлчилгээний цогцолбор байгуулна.	Монгол Улс нь 46 улстай агаарын харилцааны хэлэлцээртэй, үүнээс 23 улсын чиглэлд нислэг үйлдэж байгаагаас 10 улс нь идэвхтэй нислэгтэй байна. Үүнд: БНХАУ, БНСУ, ОХУ, Япон, ХБНГУ, БНКау, Вьетнам, Тайланд, Хонконг. Өнөөдрийн байдлаар өвлийн батлагдсан цагийн хуваарийн дагуу 23 хотын чиглэлд олон улсын нислэг үйлдэж байна. 2024 онд ИБУИНХУ, Унгар, Латви, Узбекистан, Туркменистан улстай Агаарын харилцааны хэлэлцээр шинээр байгуулж, шууд нислэг үйлдэх эрх зүйн зохицуулалтыг бүрдүүлсэн. Мөн энэ онд Кувейт, Азербайжан, Австрали, Итали, Испани, Нидерланд, Саудын Араб, Руанда, Словени, Итали улсуудтай агаарын харилцааны хэлэлцээрийн төслийг эцэслэн тохирч үзэглэсэн бөгөөд ирэх жилүүдэд талуудын өндөр, дээд хэмжээний айлчлал, арга хэмжээний үеэр хэлэлцээрүүдийг байгуулахаар төлөвлөж байна Агаарын харилцааны хэлэлцээр байгуулснаар нийт 142 цэг рүү шууд нислэг үйлдэх эрх зүйн зохицуулалтыг бүрдүүлсэн. Монгол-Солонгос хоорондын агаарын харилцааны асуудлаар талууд Сөүл хотноо 2024 оны 02 дугаар сард уулзалт, хэлэлцээ хийж Улаанбаатар-Бусан чиглэлд долоо хоногийн 6 удаагийн давтамжтай байсныг 9 болгон нэмэгдүүлж, Инчон, Гимпо, Бусан зэрэг хотуудаас бусад БНСУ-ын орон нутгийн 5 чиглэлд долоо хоногийн нийт 15 удаагийн давтамжтай байсныг 5 чиглэлд долоо хоногийн нийт 15 удаагийн давтамжтай нислэг үйлдэхээр тохиролцсон. Мөн Монгол-Солонгос хоорондын нислэгийн давтамжийг суудлын багтаамжтай уяж тооцдог байсныг халж, Улаанбаатар-Сөүлээс бусад чиглэлд аливаа багтаамжийн хязгаарлалтгүй болгож, дан давтамжаар тооцох нөхцөлийг бүрдүүлсэн. 2024 оны сүүлийн хагас жилд Чех улсын Прага, Вьетнамын Хошимин, Хятадын Ордос, Саньяа, Хайкоу хотууд руу тус тус шууд нислэгийг шинээр нэмэгдүүлээд байна. 2024 онд олон улсын өнгөрөлтийн нислэг 65.000, олон улсын хөөрөлт буултын нислэг 12.600, орон нутгийн хөөрөлт буултын нислэг 10.700, нийт 88 300 нислэг үйлдэгдсэн.	90	Зам, тээврийн яам
